



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн  
Хүний хөгжлийн судалгааны сектор

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн  
хөгжлийг судлах суурь  
судалгааны тайлан

2023 он

Судалгааны багийн бүрэлдэхүүн

Н. Бэгз

С. Санжаабадам

Б. Энхбаяр

Б. Баярмаа

Ц. Лхагвасүрэн

Э. Баясгалан

## Агуулга

<b>Нэр томъёоны тайлбар</b> .....	6
<b>Удиртгал</b> .....	8
Зорилго .....	8
<i>Зорилт</i> .....	8
<b>Нэг. Арга зүй</b> .....	9
<b>Ерөнхий мэдээлэл</b> .....	10
<b>Хоёр. Хүүхдийн танин мэдэхүй, зан төлөв сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийн онцлог</b> .....	11
2.1. Харааны хүртэхүйн онцлог.....	12
2.2. Анхаарал, ой тогтоолтын онцлог .....	14
2.2.1. Анхаарлын төвлөрөл .....	14
2.2.2. Мэдээллийг тогтоох чадвар .....	16
2.2.3. Хараад мэдээллийг тогтоох чадвар .....	16
2.2.4. Сонсоод мэдээллийг тогтоох чадвар.....	17
<b>Дүгнэлт: Мэдээллийг хүртэх, анхаарах, тогтоох чадварын онцлог</b> .....	18
2.3. Бодит дүрслэлийн сэтгэхүйн хөгжлийн онцлог .....	19
2.3.1. Бодит дүрслэлийн сэтгэхүй.....	19
2.3.2. Орон зайн дүрслэлийн сэтгэхүй.....	23
2.3.4. Хийсвэр сэтгэхүйн хөгжлийн онцлог .....	26
<b>Дүгнэлт: Сэтгэхүйн чадварын онцлог</b> .....	28
2.4. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог .....	28
2.4.1. Зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөний ерөнхий онцлог .....	28
2.4.2. Сэтгэлийн хөдөлгөөний эрч хүчтэй байдал.....	30
<b>Дүгнэлт: Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог</b> .....	31
<b>Гурав. Тусгай хэрэгцээт боловсролын хүүхдүүдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөний чадварын ерөнхий онцлог</b> .....	31
<b>3.1. Сонголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог</b> .....	31
3.1.1. Танин мэдэхүйн хөгжлийн онцлог.....	31
3.1.2. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог .....	32
<b>3.2. Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог (Аутизм)</b> .....	33
3.2.1. Танин мэдэхүйн хөгжлийн онцлог .....	33

3.2.2.	Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог .....	34
3.3.	Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог .....	35
3.3.1.	Танин мэдэхүйн хөгжлийн онцлог.....	35
3.3.2.	Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог .....	36
3.4.	Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог.....	37
3.4.1.	Танин мэдэхүйн хөгжлийн онцлог.....	37
3.4.2.	Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог .....	38
	<b>ДҮГНЭЛТ</b> .....	40
	<b>Зөвлөмж</b> .....	42
	НОМ ЗҮЙ.....	44
	Хавсралт 1. ....	45
	Хавсралт 2. ....	46
Зураг 1.	Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, насны бүлгээр (хувиар) .....	10
Зураг 2.	Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, суралцаж буй ангиар (хувиар) .....	10
Зураг 3.	Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн тогтмол унтдаг цаг, хувиар .....	11
Зураг 4.	Харааны хүртэхүйн хөгжил, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр .....	13
Зураг 5.	Бодит дүрслэлийн сэтгэхүй, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлт .....	22
Зураг 6.	Орон зай дүрслэлийн сэтгэхүйн чадавч бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр .....	25
Зураг 7.	Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйн чадвар, хувиар .....	27
Зураг 8.	Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэл санааны байдлын түвшин, хувиар...29	
Зураг 9.	Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний онцлогт дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар .....	30
Зураг 10.	Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний түвшин, хувиар ...31	
Зураг 11.	Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадваруудын түвшин, дундаж үзүүлэлтээр .....	32
Зураг 12.	Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр .....	32
Зураг 13.	Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, түвшингээр, хувиар .....	33
Зураг 14.	Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн идэвхтэй шинж, түвшин, хувиар .....	33
Зураг 15.	Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварууд, дундаж үзүүлэлтээр.....	34
Зураг 16.	Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр.....	34
Зураг 17.	Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, хувиар .....	35
Зураг 18.	Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн онцлог, хувиар .....	35
Зураг 19.	Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварууд, дундаж үзүүлэлтээр.....	36

Зураг 20. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр.....	37
Зураг 21. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, хувиар .....	37
Зураг 22. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн онцлог, хувиар .....	37
Зураг 23. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварууд, дундаж үзүүлэлтээр.....	38
Зураг 24. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр.....	39
Зураг 25. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, хувиар .....	39
Зураг 26. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн онцлог, хувиар .....	39

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, бэрхшээлийн төрлөөр, хувиар.....	11
Хүснэгт 2. Хүүхдүүдийн танин мэдэхүй, нийгэмшлийн чадварууд, хүчин зүйлийн шинжилгээ .....	11
Хүснэгт 3. Харааны хүртэхүйн чадварын даалгавруудын статистик үр дүн.....	12
Хүснэгт 4. Харааны хүртэхүйн чадварын хөгжлийн түвшин, хувиар.....	12
Хүснэгт 5. Хүртэхүйн чадварын түвшинд дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар.....	14
Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх чадварын статистик үзүүлэлт .....	14
Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэн гүйцэтгэсэн даалгаврын тоо, статистик үзүүлэлт .....	14
Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх чадвар, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр .....	15
Хүснэгт 9. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлын сарнилт/ядралт, бэрхшээлээр, гүйцэтгэсэн даалгаврын тоогоор .....	15
Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх хөгжлийн түвшинд дугуйланд хамрагдалтын нөлөөлөл, хувиар .....	16
Хүснэгт 11. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн харааны ой тогтоолтын даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ .....	16
Хүснэгт 12. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн харааны ойн чадварын статистик үзүүлэлт, дундаж үзүүлэлтээр .....	17
Хүснэгт 13. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн харааны ойн чадвар, бэрхшээлийн төрлөөр, статистик үзүүлэлт .....	17
Хүснэгт 14. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сонорын ой тогтоолтын даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ .....	17
Хүснэгт 15. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сонорын ой тогтоолтын статистик үзүүлэлт .....	18
Хүснэгт 16. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүйн чадварын хүчин зүйлийн шинжилгээ .....	19
Хүснэгт 17. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүйн чадварын статистик үзүүлэлт .....	20
Хүснэгт 18. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүй, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр .....	20
Хүснэгт 19. Бодит дүрслэлийн сэтгэхүй ба цэцэрлэгт хамрагдалт хоорондын статистик ялгаа .....	21
Хүснэгт 20. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүй, бэрхшээлийн төрлөө, статистик үзүүлэлт .....	21

Хүснэгт 21. Бодит дүрслэлийн сэтгэхүй-харьцуулах чадварт цэцэрлэлт хамрагдсан байдлын нөлөө, хувиар .....	22
Хүснэгт 22. Бодит дүрслэлийн сэтгэхүй-задлан шинжлэх чадварт цэцэрлэгт хамрагдсан байдлын нөлөө, хувиар.....	23
Хүснэгт 23. Бодит дүрслэлийн сэтгэхүйн хөгжилд дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар .....	23
Хүснэгт 24. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн орон зайн дүрслэлийн сэтгэхүйн даалгавруудын хүчин зүйлийн шинжилгээ .....	23
Хүснэгт 25. Судалганад хамрагдсан хүүхдүүдийн орон зайн дүрслэлийн сэтгэхүйн статистик үзүүлэлт .....	24
Хүснэгт 26. Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварын статистик үзүүлэлт .....	24
Хүснэгт 27. Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварт бэрхшээлийн ялгаатай байдлын нөлөө, статистик үзүүлэлт.....	25
Хүснэгт 28. Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварт цэцэглэт хамрагдалтын нөлөө, хувиар .....	26
Хүснэгт 29. Орон зайн дүрслэлийн сэтгэхүүд дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар.....	26
Хүснэгт 30. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хийсьэр сэтгэхүйн даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ .....	26
Хүснэгт 31. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйн с татистик үзүүлэлт..	27
Хүснэгт 32.Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөө, зан төлөвийн даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ .....	28
Хүснэгт 33. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний түвшин, статистик үзүүлэлт .....	29
Хүснэгт 34. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний онцлогт дугуйланд хамрагдалтын нөлөө, статистик үзүүлэлт .....	30
Хүснэгт 35. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний эрч хүчтэй байдал, статистик үзүүлэлт .....	30

## Нэр томъёоны тайлбар

Ажигч чанар – юмс үзэгдэл, түүнийг бүрдүүлэгч хэсгүүд, шинж чанарыг зорилготойгоор анхааран богино хугацаанд ажиглах хүртэхүйн чадвар.

Ажиллах чадвар – тодорхой хугацааны турш үйл ажиллагааг үр дүнтэй, тууштай гүйцэтгэх хувь хүний чадвар.

Анхаарлын тогтворжилт – удаан хугацааны турш юмс үзэгдэлд сэтгэц ухамсраа зориудаар төвлөрүүлэх чадвар.

Анхаарлын шилжилт – зорилго чиглэлтэйгээр сэтгэц ухамсраа нэг зүйлээс өөр зүйлд, үйл ажиллагааны нэг төрлөөс өөр төрөлд шилжүүлэх чадвар.

Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтэй байдал нь хүүхдийн нийгмийн дасан зохицох байдалд бэрхшээл үүсгэдэг эмгэгийн бүрдэл хэсэг юм.

Аутизм – нийгмийн харилцаа болон хэл ярианы хөгжлийн хоцрогдол бэрхшээлийн илрэл бүхий сэтгэц мэдрэлийн эмгэг өөрчлөлт.

Богино хугацааны ой тогтоолт- хязгаарлагдмал хугацаа (15-30 секунд хүртэлх)-нд мэдрэхүйн үйл ажиллагааны тусламжтайгаар мэдээллийг тогтоон хадгалж сэргээн санах үйл явц юм.

Бодит дүрслэлийн сэтгэхүй – мэдрэхүйн эрхтэнд нөлөөлсөн юмс, үзэгдлүүдийн хэлбэр дүрс, тэдгээрийн шинж чанарыг нэгтгэн ойлгосны үндсэн дээр явагддаг сэтгэхүйн төрөл.

Бодит үйлдлийн сэтгэхүй – юмстай үйлдэл хийх замаар түүний учир шалтгаан холбоо хамаарлыг нь таньж мэддэг сэтгэхүйн төрөл.

Дауны хам шинж – ургийн хөгжлийн үед 21 дэх хромосом гурав болж хуваагдсанаас шалтгаалсан сэтгэц-физиологи, бие махбодын эмгэг өөрчлөлт.

Ой тогтоолт- гадаад болон хүний биеийн дотоодоос өгч буй янз бүрийн дохио мэдээллийг уураг тархиндаа мэдрэлийн түр холбоос байдалтайгаар тогтоох, хадгалах, сэргээн санах үйл явц юм.

Оюун ухааны хомсдол – уураг эхийн хэвлийд байх үед, эсхүл төрсний дараах 3 хүртэлх насанд гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр хүүхдийн уураг тархины хөгжил сулрах эмгэг өөрчлөлт.

Сонорын ой – мэдээллийг сонсоод тогтоож, хадгалж, сэргээн санах үйл явц.

Сэтгэлийн хөдөлгөөн – хүний төрөлхийн зөн билэг, үүсээд байгаа хэрэгцээ, сонирхол, хүсэл эрмэлзэлтэй холбоотой дотоод хандлагын илрэл болох сэтгэц процесс, байдал.

Сэтгэц оношилгоо- мэдлэг, чадвар, дадал, авьяас билэг, сэтгэцийн процесс, байдал, хүний хэрэгцээ сонирхол, хүсэл эрмэлзэл, зан төлөв, онцлог шинжийг судлан илрүүлэхэд чиглэнэ.

Сэтгэцийн эмгэг – сэтгэл мэдрэлийн өвчин бол уураг тархины үйл ажиллагаа болсон сэтгэцийн процессын эмгэг өөрчлөлт мөн.

Танин мэдэхүй – юмсын мөн чанар, зүй тогтлын талаар мэдлэг, туршлага эзэмших үйл явц, зарчим аргуудын нэгдмэл цогц ойлголт.

Хийсвэр сэтгэхүй – юмс үзэгдлийг тэмдгийн системд (ойлголт, систем, дүрслэл гэх мэт) тулгуурлан тусгаж тэдгээрийн дотоод мөн чанар, учир шалтгаан, зүй тогтлыг нь шууд бусаар танин мэдэх сэтгэхүйн төрөл.

Хараа хөдөлгөөний зохицуулах чадвар - Хараа, хүртэхүй болон гарын жижиг булчингийн хөдөлгөөний үндсэн дээр явагддаг чадвар юм.

Хэл ярианы эмгэг – тархины зүүн тал бөмбөлгийн бүсийн органик гэмтлийн улмаас бий болсон хүний ярих, ойлгох чадварын алдагдал.

Оюуны хоцрогдол нь сэтгэцийн үйл ажиллагаа болох ой тогтоолт, анхаарал, сэтгэхүй, сэтгэл хөдлөл нь тухайн насны сэтгэл зүйн төвшнөөс хоцрогдож танин мэдэхүйн хөгжилд нөлөөлөх байдлыг хэлдэг.

Хавсарсан бэрхшээл - нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулна.



## Удиртгал

Монгол Улсын үндсэн хууль, холбогдох бусад эрх зүйн баримт бичгүүдэд нийгмийн харилцаанд хүн үл ялгаварлан гадуурхах, сурч боловсрох эрх нь тэгш хангагдах талаар эрх зүйн зохицуулалтыг хийсэн байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд хүн бүр “сурч боловсрох эрхтэй” гэж заасан байдаг бол Боловсролын тухай хуульд боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр нь суралцагчийн хөгжлийн онцлогт нийцсэн байх, боловсролын агуулга нь суралцагчийн нас бие сэтгэхүйн онцлогт нийцүүлэх талаар албан ёсоор зүйлчилсэн байдаг.

Алсын хараа-2050 баримт бичигт хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог 2021-2030 онд бүрдүүлэх зорилтыг дэвшүүлжээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам” /БСШУС-ын сайдын А/292 дугаар тушаал/-ын хүрээнд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдийн ялгаатай хэрэгцээ, сонирхлыг харгалзан суралцахуйг оновчтой төлөвлөн, сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгаа. Мөн хүүхдийн хэрэгцээнд суурилсан хэл яриа, танин мэдэхүй, бие бялдрын хөгжлийг дэмжих арга технологи нэн шаардлагатай байна.

БШУЯ, ШУТС-тай хамтран БСҮХ нь “Монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг тогтоох” хоёр удаагийн цөм болон суурь судалгааг 3-21 насны хүүхэд залуучуудыг хамруулан үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн.

Эхний шатны судалгаанд сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучууд болон насан туршийн боловсролын төвөөр боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн онцлогийг судалсан. Судалгааны үр дүнд эдгээр хүүхдүүдийн чадвар харьцангуй сул гарсан нь цаашид тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн хөгжлийн онцлогийг тогтоож, сургалт, хөгжлийн үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн тэгш, чанартай боловсрол эзэмших, хөгжих боломжийг илрүүлэх зайлшгүй шаардлага тулгарсан.

Энэхүү хэрэгцээ шаардлагын улмаас бид эхний ээлжинд тусгай хэрэгцээт боловсролын бага ангийн сурагчдын танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлогийг тогтох судалгаа хийлээ.

## Зорилго

Тусгай хэрэгцээт боловсролын 6-10 насны хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлогийг тогтоож санал, зөвлөмж боловсруулах

## Зорилт

1. Хүүхдийн нийгэмшил, танин мэдэхүйн чадваруудын хөгжлийн онцлогийг тогтоох
2. Хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх
3. Хүүхдийн танин, мэдэхүй нийгэмшлийн хөгжлийг дэмжих арга зүйн санал, зөвлөмж боловсруулах

## Нэг. Арга зүй

Тусгай хэрэгцээт боловсролын хүүхдүүдийн танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлогийг тодорхойлохдоо тестийн аргыг хэрэглэсэн.

Танин мэдэхүйн чадварыг бодит дүрслэлийн сэтгэхүй, хийсвэр сэтгэхүй, анхаарлаа төвлөрүүлэх, богино хугацаанд мэдээллийг харж тогтоох, сонсож тогтоох чадварын хүрээнд судаллаа.

Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг сэтгэл санааны байдал, зан төлөвийн шинжийн хүрээнд судаллаа.

Хүртэхүйн чадвар: хараа-хөдөлгөөний зохицуулалтыг судлах Бендерийн *гештальт* тестийн аргаар судалсан.

Тухайн тест нь хүүхдийн харж хүртэх чадвар, хуруу хөдөлгөөний чадварыг оношлоход чиглэнэ.

Богино хугацаанд мэдээллийг харж тогтоох чадвар: Дүрс, зургийг хараад дэс дарааллаар нь тогтоох аргаар судаллаа. (12 дүрс, зураг)

Богино хугацаад үгийг сонсож тогтоох чадвар: 10 үг сонсоод сэргээн санах аргаар судаллаа (А.Р.Лурнигийн арга).

Анхаарлаа төвлөрүүлэх чадвар: Хүүхдийн анхаарлаа төвлөрүүлэх чадварыг гүйцэтгэлийн хурд, оновчтой байдлаар нь тогтоов. Даалгарыг сонгохдоо хөгжлийн онцлогийг нь харгалзан үзэж энгийн дүрс тэмдэглэгээг харж дүрсүүдийг тэмдэглэх аргаар судаллаа (Пьер-Рузений арга)

Бодит дүрслэлийн сэтгэхүй: Бодит дүрслэлийн сэтгэхүйг бодит болон орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварын хүрээнд судлахдаа сэтгэхүйн харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх үйлдэл хийх чадвараар судалсан. Энд Равений тесийн аргыг хэрэглэлээ.

Хийсвэр сэтгэхүй: Зургийг ажиглан тэдгээрийг харьцуулан хоородын уялдаа холбоо зүй тогтлыг нь олох даалгавраар судаллаа.

Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг Люшерийн “өнгөний сорил”-ын аргаар судалсан.

Эрхэмлэж байгаа өнгөний дэс дарааллаар нь сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг нь судаллаа.

Судалгааны үр дүнгийн статистик шинжилгээг SPSS 26.0 хэрэглэж боловсруулсан.


Үүнд: Дескриптив статистик арга, ANOVA, Т-тест, Корреляцийн арга, Хүчин зүйлийн анализын арга, Найдвартай байдлыг тодорхойлох арга зэргийг хэрэглэн үр дүнг боловсрууллаа.

## Ерөнхий мэдээлэл

Тусгай хэрэгцээт боловсролын хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлогийг судлан тодорхойлох зорилгоор нийт 110 хүүхэд судалгаанд хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 65 хувь нь 8-10 настай хүүхдүүд байлаа.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, насны бүлгээр (хувиар)



Судалгаанд 3-5 дугаар ангийн хүүхдүүд давамгайл оролцсон буюу нийт түүврийн 77 хувийг эзэлж байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, суралцаж буй ангиар (хувиар)



Хүйсийн хувьд 59 хувь нь охид, 41 хувь нь хөвгүүд байлаа.

Нийт хүүхдүүдийн 76 хувь нь цэцэрлэгт хамрагдсан, 5 хүүхэд тутмын 2 нь хичээлээс гадуурх дугуйлан секцийн үйл ажиллагаанд хамрагддаг ажээ.


Тусгай хэрэгцээт боловсролын төрлийн хувьд аваад үзэхэд, 41 хувь нь хөнгөн хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй, 26 хувь нь зан төлөвийн бэрхшээл буюу аутизмтай хүүхдүүд байсан. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд 18 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, бэрхшээлийн төрлөөр, хувиар

Онош	Хувь	Тооцох хувь	Өсөн нэмэгдэх хувь
Сонголын бэрхшээл	17.8	18.0	18.0
Зан төлөвийн бэрхшээл	25.7	26.0	44.0
Оюун ухааны бэрхшээл	40.6	41.0	85.0
тулгуур эрхтний бэрхшээл	11.9	12.0	97.0
харааны бэрхшээл	3.0	3.0	100.0

Хүүхдүүдийн орой тогтмол унтдаг цагийг сонирхож үзэхэд, 74 хувь нь 21-22 цагт унтдаг байна.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн тогтмол унтдаг цаг, хувиар



## Хоёр. Хүүхдийн танин мэдэхүй, зан төлөв сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийн онцлог

Хүүхдүүдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг 9 чадварын хүрээнд судалсан ба даалгаврын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь харилцан хамаарал бүхий 3 бүрэлдэхүүнийг үүсгэж байгаа тул сорилын тохироц чанар хангагдаж байна гэж үзлээ.

Хүчин зүйлийн шинжилгээнээс харахад, танин мэдэхүйн чадвар дотроос сонсоод мэдээллийг тогтоож сэргээн санах болон хийсвэр сэтгэхүйн чадвар нь харилцан хамааралтай хөгждөг бөгөөд сонсоод үгийг тогтоож сэргээн санах чадвар нь хийсвэр сэтгэхүйн хөгжлийг дэмжихэд давамгайл үүрэгтэй байна.

Бусад харааны хүртэхүй, анхаарлын төвлөрөл, бодит дүрслэлийн сэтгэхүйн хөгжилд хамгийн чухал ач холбогдолтой нь бодит дүрслэлийн сэтгэхүй ялангуяа орон зайн сэтгэхүй чухал ач холбогдолтой байна.

Нийгэмшлийн чухал чадвар болох сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөв, эрч хүчтэй зан төлөвийг судлах даалгавар нь нэг багц болж чадаж байгаа тул тухайн сорилын даалгавар нь шаардлага хангахуйц байлаа.

Хүснэгт 2. Хүүхдүүдийн танин мэдэхүй, нийгэмшлийн чадварууд, хүчин зүйлийн шинжилгээ

Сорилын даалгавар	Бүрэлдэхүүн		
	1	2	3

Харж мэдээллийг хүртэх хүртэхүйн түвшин	.674		
Анхаарлаа төвлөрүүлэх чадварын түвшин	.723		
Харж мэдээллийг тогтоож сэргээн санах чадварын түвшин	.601		
Сонсоод мэдээллийг тогтоох сэргээн санах чадварын түвшин			.745
Бодитоор юмсыг харж сэтгэх сэтгэхүйн түвшин /бодит сэтгэхүй	.788		
Бодитоор юмсыг харж бүтэц, бүрэлдэхүүн, дэс дарааллаалд нь сэтгэх сэтгэхүйн түвшин/орон зайн сэтгэхүйн	.806		
Хийсвэр сэтгэхүйн түвшин			.634
сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог		.811	
эрч хүчтэй байдлын түвшин		.812	

### 2.1. Харааны хүртэхүйн онцлог

Харааны хүртэхүйн онцлогийг судлан тодорхойлох зорилгоор дүрс харж дуурайн зурах үйлдлийг хүүхдүүдээр хийлгэв.

Даалгаврын хүчин зүйлийн шинжилгээгээр тохироц ба найдвартай байдал нь хангалттай түвшинд байна. Өөрөөр хэлбэл, харааны хүртэхүйн чадварыг тодорхойлох даалгаврууд нь харилцан хамааралтай нэг багц үүсгэж байгаа ба Кронбах альфа коэффициентийн утга нь өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Харааны хүртэхүйн чадварын даалгавруудын статистик үр дүн

	Хүчин зүйлийн коэффициент	Статистик дундаж үзүүлэлт (Mean)	Стандарт хазайлт	Стандарт алдаа	Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
Даалгавар дүрс зураг - 1	.898	2.87	1.231	.111	.912
Даалгавар дүрс зураг -2	.891	3.09	1.195	.126	
Даалгавар дүрс зураг -3	.878	2.68	1.223	.123	
Даалгавар дүрс зураг -4	.894	2.61	1.240	.125	
Харааны хүртэхүйн чадвар		2.97	1.240	.121	

Нийт хүүхдүүдийн хувьд, харааны хүртэхүйн чадвар дундаж хэвийн түвшинд байна (M=2.80). Гэвч стандарт хазайлтаас харахад, хүүхдүүдийн түвшин харилцан адилгүй буюу жигд бус байна. Гурван хүүхэд тутмын нэг нь сул түвшинд байна.

Хүснэгт 4. Харааны хүртэхүйн чадварын хөгжлийн түвшин, хувиар


	Хувь	Тооцох хувь	Нэмэгдсэн хувь

Valid	маш сул	10.9	11.7	11.7
	сул	20.8	22.3	34.0
	дундаж	26.7	28.7	62.8
	сайн	26.7	28.7	91.5
	маш сайн	7.9	8.5	100.0
	Total	93.1	100.0	
Бүгд		100.0		

Юмсыг харж ойлгоходоо ерөнхий дүрс хэлбэрийг нь ойлгож, тэдгээрийн бүтэц элементийг салангид байдлаар хүртдэг хэдий ч нарийн элементүүдийг нь ойлгох нь хангалтгүй тул түүнийг дэмжих хэрэгцээтэй нь харагдлаа.


Энэ чадвар нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн ялгаанаас хамаарч ялгаатай байна. ( $p=0.00$ )

Зураг 4. Харааны хүртэхүйн хөгжил, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр





Судалгаанд хамрагдсан хөнгөн харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн чадвар бүгд дунджаас дээш бол тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийнх 83 хувь нь, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн 50 хувь нь, зан төлөвийн бэрхшээл буюу аутизмтай хүүхдүүдийн 24 хувь нь, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн 20 хувь нь дунджаас дээгүүр түвшинд байна.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 31 хувь нь хэвийн дундаж түвшинд бол 35 хувь нь сул түвшинд, 32 хувь нь сайн түвшинд байгаа нь анхаарал татахуйц байна.



Даалгаврын гүйцэтгэл тус бүрээр нь авч үзэхэд, хамгийн сайн гүйцэтгэлтэй нь хоорондоо шүргэлцсэн дугуй ба ромбо дүрс байна. Үүнийг судалгаанд оролцогчдын 44 хувь нь сайн түвшинд гүйцэтгэжээ.



Харин харьцангуй сул гүйцэтгэлтэй нь зах хэсгээрээ хоорондоо огтлолцсон туузан дүрс, дөрвөн эгнээ бүхий конусан дүрс байна.

Эдгээрийг судалгаанд оролцогчдын 24 хувь нь сайн гүйцэтгэжээ.

Хүүхдүүдийн **хичээлээс гадуурх секц дугуйланд хамрагддаг** эсэх нь тэдний харж мэдээллийг хүртэх буюу дүрс зургийг хараад бүхэлд нь хүртэх, тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүнийг нь ажиглан хүртэх чадварт нь статистик ач холбогдлын түвшинд эерэгээр нөлөөлжээ ( $p=0.00$ ).

Судалгаанд хамрагдсан 2 хүүхэд тутмын 1 нь дугуйланд хамрагддаг бөгөөд дугуйланд хамрагддаг хүүхдүүдийн харж мэдээллийг хүртэх, бүтэц бүрэлдэхүүнийг нь ажиглах нь дунджаас доогуур түвшинд ( $M=2.7$ ) бол дугуйланд явдаг гэж хариулсан хүүхдүүдийнх дунджаас дээгүүр түвшинд байна ( $M=3.5$ ) байна.

Хүснэгт 5. Хүртэхүйн чадварын түвшинд дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар

		Харааны хүртэхүйн хөгжлийн түвшин					Бүгд
		маш сул	сул	дундаж	сайн	маш сайн	
Үгүй	Дугуйланд хамрагддаг эсэх	18.2%	27.3%	30.9%	18.2%	5.5%	100.0%
Тийм		2.6%	15.4%	25.6%	43.6%	12.8%	100.0%

Дээрх хүснэгтээс харахад, дугуйланд хамрагдаг хүүхдүүдийн харж мэдээллийг бүхэлд нь хүртэх, бүтэц бүрэлдэхүүнийг ажиглах чадвар нь 56 хувьд нь хангалттай түвшинд байхад дугуйланд хамрагддаггүй хүүхдүүдийн 24 хувь нь тухайн түвшинд байна.

## 2.2. Анхаарал, ой тогтоолтын онцлог

### 2.2.1. Анхаарлын төвлөрөл

Энгийн дүрс тэмдэгтийг анхаарлаа төвлөрүүлэн гүйцэтгэх чадвар дундаж түвшинд байна ( $M=3.14$ ) Ойролцоогоор 1 минутад 18 энгийн дүрс тэмдэгтийг тэмдэглэдэг байна.

Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх чадварын статистик үзүүлэлт

	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Дундаж /Mean	Стандарт алдаа	
Анхаарлын төвлөрөл түвшин	1	5	3.14	.114	1.099

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэн гүйцэтгэсэн даалгаврын тоо, статистик үзүүлэлт

	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Mean	Стандарт алдаа	
Гүйцэтгэсэн даалгаврын тоо	0	32	18.11	.781	7.488


Хүүхдүүдийн гүйцэтгэлийн төрөлд **тусгай хэрэгцээт боловсролын хүүхдийн ялгаатай байдал** нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна ( $p<0.05$ ).

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд даалгаврыг сайн түвшинд гүйцэтгэсэн бол за н төлөвийн болон оюуны хөнгөн хэлбэр, тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дундаж түвшинд гүйцэтгэжээ.

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх чадвар, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр

онош	Дундаж /Mean	Бага утга	Их утга	Стандарт хазайлт	Стандарт алдаа
Сонсголын бэрхшээл	3.94	дундаж	маш сайн	.873	.206
зан төлөвийн бэрхшээл - аутизм	2.96	маш сул	маш сайн	1.197	.244
оюуны бэрхшээл	3.00	маш сул	маш сайн	.985	.169
тулгуур эрхтний бэрхшээл	3.00	сул	маш сайн	1.128	.326
харааны бэрхшээл	3.00	дундаж	дундаж	.000	.000
Бүгд	3.18	маш сул	маш сайн	1.081	.113

Хүснэгт 9. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлын сарнилт/ядралт, бэрхшээлээр, гүйцэтгэсэн даалгаврын тоогоор



Дээрх зургаас харахад, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн гүйцэтгэл харьцангуй сайн байгаа хэдий ч дараагийн 2 дахь минутад буурсан дүр зурагтай. Энэ нь анхаарлын төвлөрөл хурдан сарнидаг магадлалтай юм.

Харин зан төлөвийн буюу аутизмтай хүүхдүүдийн хурд бага ч хэмнэл нь жигд байна.

Мөн хичээлээс гадуур дугуйлан секцэд хамрагддаг эсэх нь хүүхдүүдийн даалгаврын гүйцэтгэлд нөлөөлсөн үр дүн харагдлаа.

**Дугуйланд хамрагддаг эсэх** нь анхаарлаа төвлөрүүлэх чадварт нь статистик ач холбогдлын түвшинд нөлөөлжээ ( $P < 0.01$ ).

Дугуйланд хамрагддаггүй гэсэн хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх чадвар нь дунджаас бага зэрэг доогуур түвшинд ( $M=2.8$ ) бол хамрагддаг гэж хариулсан хүүхдүүдийнх дундаж түвшинд байна ( $M=3.3$ )



Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх хөгжлийн түвшинд дугуйланд хамрагдалтын нөлөөлөл, хувиар

		Анхаарлын төвлөрөл					Total
		маш сул	сул	дундаж	сайн	маш сайн	
Үгүй	Дугуйланд явдаг эсэх	5.7%	37.7%	28.3%	18.9%	9.4%	100.0%
Тийм		0.0%	15.4%	33.3%	33.3%	17.9%	100.0%

Дээрх хүснэгтээс харахад, дугуйланд яваггүй гэж хариулсан хүүхдүүдийн 28 хувь нь хангалттай сайн түвшинд байхад дугуйланд явдаг гэсэн хүүхдүүдийн 51 хувь нь тухайн түвшинд байгаа нь харьцангуй ялгаатай байдлыг харуулж байна.

### 2.2.2. Мэдээллийг тогтоох чадвар

Судалгаанд оролцогчдын мэдээллийг тогтоох чадварыг дүрс зураг харж тогтоох, сонсоод мэдээллийг тогтоох чадварын хүрээнд судаллаа.

### 2.2.3. Хараад мэдээллийг тогтоох чадвар

Хүүхдүүдийн даалгаврын гүйцэтгэлийн найдвартай байдлын үзүүлэлт нь хангалттай буюу  $\alpha=0.86$ , даалгаврын хоорондын хамаарлаар нь үзэхэд 3 бүрэлдэхүүнийг үүсгэж байна. Хамгийн эхэлж тогтоож сэргээн санахад хялбар дүрсүүд нь эхний 3 дүрс байна.

В үсэг, дугуй дүрс, сүх, завьны зураг гэх мэт дүрсийг тогтоож сэргээн санаж чаддаг байх тусам бусад мод, муур гэх мэт дүрсүүдийг илүү тогтоож сэргээн санадаг байна. Эрвээхэй зургийг тогтоож сэргээн санаж чадсан хүүхдүүд 2 гэсэн цифрийг сэргээн санах нь илүү байжээ.

Эндээс харахад хүүхдүүд ахуйн, өдөр тутам бус тохиолддог юмсыг дүрсийг тогтоож сэргээн санаж чадаж байгаа тохиолдолд хараад юмсыг тогтоох чадвар сайжирдаг ажээ. Хүчин зүйлийн шинжилгээнээс харахад, даалгаврын тохироц чанар шаардлага хангахуйц байна.

Хүснэгт 11. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн харааны ой тогтоолтын даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ

Даалгавар-Тогтоох дүрс	Хүчин зүйлийн коэффициент			Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
	1	2	3	
гурвалжин дүрс		.741		0.86
бөмбөгний зураг		.762		
байшингийн зураг		.759		
эрвээхийн зураг			.868	
дөрвөлжин дүрс	.372			
модны зураг	.432			
муурны зураг	.441			
завьны зураг	.611			
В үсэг	.729			
дугуй дүрс	.747			
2 цифр			.606	
сүхний зураг	.733			

Доор хүснэгтээс харахад, хүүхдүүд энгийн дүрс зургийг хараад дунджаар 6-7 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг байна.

Хүснэгт 12. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн харааны ойн чадварын статистик үзүүлэлт, дундаж үзүүлэлтээр

	Бага утга	Доод утга	Дундаж утга		Стандарт хазайлт
			Стандарт үзүүлэлт	Стандарт алдаа	
Сэргээн санасан тоо	0	12	6.52	.34	3.34
Харааны ой түвшин	1	5	2.98	.12	1.17

Хүүхдүүдийн хараад мэдээллийг тогтоох чадвар нь **тусгай хэрэгцээт боловсролын хүүхдүүдийн ялгаатай байдлаас** хамаарсан статистик ач холбогдолтой ялгаа ажиглагдлаа ( $p=0.02$ ).

Хүснэгт 13. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн харааны ойн чадвар, бэрхшээлийн төрлөөр, статистик үзүүлэлт

	Mean	Std. Deviation	Std. Error	95% Confidence Interval for Mean		Minimum	Maximum
				Lower Bound	Upper Bound		
Сонсголын бэрхшээл	3.61	1.037	.244	3.10	4.13	1	5
зан төлөвийн бэрхшээл	3.00	1.142	.233	2.52	3.48	1	5
оюуны бэрхшээл	2.65	1.098	.188	2.26	3.03	1	5
тулгуур эрхтний бэрхшээл	2.83	1.267	.366	2.03	3.64	1	5
харааны бэрхшээл	4.00	1.000	.577	1.52	6.48	3	5
Бүгд	3.00	1.164	.122	2.76	3.24	1	5

Сонсголтой бэрхшээлтэй хүүхдүүдийн мэдээллийг хараад тогтоох чадвар нь сайн байгаа бол тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийнх дундаж, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийнх дунджаас бага зэрэг доогуур үзүүлэлттэй байлаа.

#### 2.2.4. Сонсоод мэдээллийг тогтоох чадвар

Сонсоод үгийг тогтоох чадварыг 10 үг тогтоолгох аргаар судалсан ба найдвартай байдлын үзүүлэлт нь статистик хангалттай түвшинд байна. Даалгаврын гүйцэтгэлээр авч үзэхэд, харилцан хамаарлын хувьд 4 бүрэлдэхүүнийг үүсгэж байгаа тул тохироц байдал тухайн хүүхдүүдийн чадварт нийцсэн гэж үзлээ.

Хүснэгт 14. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сонорын ой тогтоолтын даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ

Даалгавар-Тогтоох дүрс	Хүчин зүйлийн коэффициент				Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
	1	2	3	4	
мод		.931			
хүүхэлдэй		.612			

сэрээ				.852	0.760
цэцэг		.385		.759	
машин			.691		
аяга			.796		
шувуу	.839				
зураг	.736				
хүн	.798				
ном	.667				

Хүүхдүүдийн сонорын ой тогтоолт сул түвшинд байна (M=1.94). Богино хугацаанд дунджаар 3-4 үгийг тогтоодог байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарсан ялгаатай үзүүлэлт алга байлаа.

Хүснэгт 15. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сонорын ой тогтоолтын статистик үзүүлэлт

онош		Сэргээн санасан үг тоо	түвшин
Сонсголын бэрхшээл	Mean	3.71	2.00
	N	17	17
	Std. Deviation	2.201	.866
	Std. Error of Mean	.534	.210
зан төлөвийн	Mean	3.38	1.75
	N	24	24
	Std. Deviation	1.715	.676
	Std. Error of Mean	.350	.138
оюуны бэрхшээл	Mean	4.00	2.07
	N	27	28
	Std. Deviation	2.402	.900
	Std. Error of Mean	.462	.170
тулгуур эрхтний бэрхшээл	Mean	4.33	2.00
	N	12	12
	Std. Deviation	1.231	.426
	Std. Error of Mean	.355	.123
харааны бэрхшээл	Mean	3.33	1.67
	N	3	3
	Std. Deviation	1.528	.577
	Std. Error of Mean	.882	.333
Total	Mean	3.78	1.94
	N	83	84
	Std. Deviation	1.994	.766
	Std. Error of Mean	.219	.084

### Дүгнэлт: Мэдээллийг хүртэх, анхаарах, тогтоох чадварын онцлог

Юмсыг хүртэж ойлгохдоо ерөнхий байдлаар хүртэж, бүтэц бүрэлдэхүүнийг ажиглан хүртэх нь сул. Иймд тухайн чадварыг сургалт хөгжлийн үйл ажиллагаагаа дэмжих шаардлагатай нь харагдлаа. Хүүхдүүдийн тухайн чадвар нь харилцан адилгүй байна. Статистик үр дүнгээс харахад, 3 хүүхэд тутмын 1 нь хөгжлийн сул түвшинд байлаа. Тухайн чадвар нь хүүхдүүдийн

бэрхшээлийн төрлөөс хамаарчээ ( $p < 0.01$ ). Зан төлөвийн болон оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийнх харьцангуй сул байлаа. Харин хөнгөн харааны бэрхшээлтэй, тэрчлэн сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн юмсын бүтэц бүрэлдэхүүнийг ажиглан хүртэх чадвар нь сайн байна.

Сонирхлыг татсан хялбар зүйлд анхаарлаа төвлөрүүлдэг, зориудаар анхаарлаа төвлөрүүлэхдээ бэрхшээдэг, анхаарал нь үйл ажиллагааны явцад сарних магадлалтай тул түүнийг сургалт хөгжлийн үйл ажиллагаандаа харгалзан үзэх нь чухал байна.

Энгийн дүрс зургийг хараад богино хугацаанд 6-7 хүртэлхийг, сонсоод богино хугацаанд 3-4 үгийг тогтоодог онцлогтой.

Хүүхдүүдийн мэдээллийг хүртэх чадварт хичээлээс гадуур дугуйлан секцэд явдаг эсэх нь ач холбогдолтой түвшинд нөлөөлжээ ( $p < 0.01$ ), дугуйланд явдаг хүүхдүүдийнх харьцангуй эерэг түвшинд байна.

### 2.3. Бодит дүрслэлийн сэтгэхүйн хөгжлийн онцлог

Бодит сэтгэхүйн хөгжлийн онцлогийг бид Равений сэтгэхүйг судлах сорилын тусламжтайгаар судаллаа. Хүүхдүүдийн янз бүрий хэлбэр дүрс бүхий дүрсүүдийг хараад тэдгээрийг харьцуулан ялгаатай ба төстэй тал, дэс дарааллыг ойлгох сэтгэхүйн үйлдлийг судлагдахуунаа болголоо. Эдгээрийн үндсэн дээр хүүхдүүдэд давамгайлж байгаа сэтгэхүйн үйлдлийг судлах зорилго тавилаа.

Хүүхдүүдийн гүйцэтгэлээс харахад, сорилын найдвартай байдлын түвшин нь статистик шаардлагыг хангасан бөгөөд сэтгэхүйн үйлдлийг шаардаж байгаа түвшнээрээ 3 бүрэлдэхүүнийг үүсгэсэн тул тохироцтой гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, хүнд хөнгөний зэргээрээ гүйцэтгэл нь харилцан хамааралтай байж чадаж байна.

#### 2.3.1. Бодит дүрслэлийн сэтгэхүй

Бодит дүрслэлийн сэтгэхүй нь харааны дүрслэлийн сэтгэхүйн хамгийн энгийн анхдагч үе шат юм. Энэ нь янз бүрийн дүрс, хэлбэр, тэдгээрийг бүрэлдэхүүний элементийг хооронд нь харьцуулах, дэс дарааллыг нь ойлгох сэтгэхүйн үйлдэл юм. Харааны хүртэхүйгээс ялгагдах ялгаа нь сэтгэхүйн үйлдлүүд хийгдэж байдаг.

Хүснэгт 16. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүйн чадварын хүчин зүйлийн шинжилгээ

Даалгавар	Хүчин зүйлийн коэффициент			Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
	1	2	3	
Бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 1		.884		0.78
Бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 2		.855		
Бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 3		.571		
Бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 4	.806			
Бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 5	.719			

бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 6	.834		
бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 7			.398
бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 8			.570
бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 9			.620
бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 10			.603
бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 11			.327
бодит дүрслэлийн сэтгэхүй даалгавар 12			.588

Хүүхдүүдийн гүйцэтгэлээс харахад, бодит дүрслэлийн сэтгэхүйн чадвар нь дундаж хэвийн түвшинд байна (M=3.2).

Хүснэгт 17. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүйн чадварын статистик үзүүлэлт

	Бага утга	Их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Статистик утга	Стандарт алдаа	
бодит дүрслэлийн сэтгэхүй түвшин	1	5	3.20	.109	1.035

Даалгаврын гүйцэтгэлээс харахад, хүүхдүүд харагдаж байгаа гадаад шинжид нь тулгуурлан сэтгэн боддог байна (M=4.3). Өөрөөр хэлбэл, юмсыг гадаад шинжээр нь бүхэлд нь ойлгож сэтгэдэг онцлогтой байна.

Харин үзэгдэл юмсыг бүрдүүлдэг бүтэц бүрэлдэхүүнийг нь таньж ойлгож задлан шинжилж нэгтгэн дүгнэх үйлдэл хангалтгүй байна (M=2.4).

Хүснэгт 18. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүй, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр

онош		Гадаад шинжид нь тулгуурлан сэтгэх сэтгэхүй	Задлан шинжилж нэгтгэн дүгнэх үйлдлийн түвшин
Сонголын бэрхшээл	Дундаж үзүүлэлт/mean	4.94	3.22
	Нийт	18	18
	Стандарт хазайлт	.236	.943
	Стандарт алдаа	.056	.222
зан төлөвийн бэрхшээл	Дундаж үзүүлэлт/mean	4.16	2.16
	Нийт	25	25
	Стандарт хазайлт	1.313	1.143
	Стандарт алдаа	.263	.229
Оюун ухааны бэрхшээл	Дундаж үзүүлэлт/mean	3.91	2.09
	Нийт	32	32
	Стандарт хазайлт	1.400	1.304
	Стандарт алдаа	.247	.231
Бие махбодын бэрхшээл	Дундаж үзүүлэлт/mean	4.75	2.42
	Нийт	12	12

	Стандарт хазайлт	.622	1.165
	Стандарт алдаа	.179	.336
харааны бэрхшээл	Дундаж үзүүлэлт/mean	5.00	3.00
	Нийт	3	3
	Стандарт хазайлт	.000	1.000
	Стандарт алдаа	.000	.577
	Дундаж үзүүлэлт/mean	4.33	2.41
Нийт	Нийт	90	90
	Стандарт хазайлт	1.180	1.226
	Стандарт алдаа	.124	.129

Бодит дүрслэлийн сэтгэхүйн чадвар нь **тусгай хэрэгцээт боловсролын хүүхдийн ялгаатай байдал** болон **цэцэрлэгт хамрагдаж байсан** эсэхээс хамаарсан статистик ялгаатай байна ( $p < 0.01$ ).

Хүснэгт 19. Бодит дүрслэлийн сэтгэхүй ба цэцэрлэгт хамрагдалт хоорондын статистик ялгаа


	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Between Groups	13.361	4	3.340	3.631	.009
Within Groups	78.194	85	.920		
Total	91.556	89			

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүй буюу юмсыг хараад шинжүүдийг нь хооронд харьцуулах, ялгаатай ба төсөөтэй талыг нь таних, дэс дараалалд нь сэтгэх сэтгэхүйн чадвар нь сайн байна. Харин оюун ухааны хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийнх харьцангуй сул байлаа.

Хүснэгт 20. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүй, бэрхшээлийн төрлөө, статистик үзүүлэлт

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Дундаж үзүүлэлт/Mean	N	Стандарт хазайлт	Стандарт алдаа
сонсголын	3.89	18	.471	.111
зан төлөвийн бэрхшээл	2.80	25	1.225	.245
оюун ухааны бэрхшээл	3.13	32	1.040	.184
тулгуур эрхтний бэрхшээл	3.25	12	.622	.179
харааны бэрхшээл	3.67	3	.577	.333
Нийт	3.22	90	1.014	.107

Зураг 5. Бодит дүрслэлийн сэтгэхүй, бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлт



Дээрх зургаас харахад, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн юмсыг гадаад харагдаж байгаа шинж байдал дээр тулгуурлан бүхэлд нь дүрслэн ойлгох нь маш сайн, бүтэц бүрэлдэхүүнийг нь таньсны үндсэн дээр нэгтгэн дүгнэх сэтгэхүйн аналитик үйлдэл нь дундаж түвшинд байна.

Бие махбодын бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд гадаад харагдаж байгаа шинж байдалд нь тулгуурлан дүрслэн ойлгож сэтгэх нь маш сайн түвшинд, гэтэл бүтэц бүрэлдэхүүнд нь задлан шинжилж нэгтгэн дүгнэх сэтгэхүйн чадвар хангалтгүй байна.

Зан төлөвийн бэрхшээлтэй буюу аутизмтай, мөн оюун ухааны хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүдийн юмсыг гадаад шинж байдал дээр нь тулгуурлан дүрслэн ойлгож сэтгэх нь сайн бол харин бүтэц бүрэлдэхүүнийг нь таньж задлан шинжилж нэгтгэн дүгнэх сэтгэхүй сул байна.

**Цэцэрлэгт явсан эсэх** нь хүүхдүүдийн бодит дүрслэлийн сэтгэхүйд статистик ач холбогдлын түвшинд нөлөөлжээ.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ойролцоогоор 4 хүүхэд тутмын 1 нь цэцэрлэгт яваагүй байсан ба тэдний сэтгэхүйн тухайн чадвар нь дунджаас дээгүүр түвшинд бол цэцэрлэгт явсан хүүхдүүдийнх сайн түвшинд байна ( $P < 0.01$ ;  $M = 3.7$ ;  $M = 4.5$ ).

Үүнийг хөгжлийн түшингээр нь тодруулан авч үзэхэд, цэцэрлэгт хамрагдсан гэж хариулсан хүүхдүүдийн юмсыг гадаад харагдаж байгаа шинж байдалд нь тулгуурлан ерөнхий байдлаар хүртэж ойлгох чадвар нь явж байгаагүй гэж хариулсан хүүхдүүдээс харьцангуй сайн түвшинд байна.

Хүснэгт 21. Бодит дүрслэлийн сэтгэхүй-харьцуулах чадварт цэцэрлэгт хамрагдсан байдлын нөлөө, хувиар

		Гадаад шинжид нь тулгуурлан сэтгэх сэтгэхүй					Бүгд
		маш сул	маш сул	сул	дундаж	сайн	
Үгүй	Цэцэрлэгт явсан эсэх	17.4%	4.3%	17.4%	13.0%	47.8%	100.0%
Тийм		2.9%	4.4%	4.4%	14.7%	73.5%	100.0%

Цэцэрлэгт явсан хүүхдүүдийн бүхлээс бүтэц бүрэлдэхүүнийг ялгаж сэтгэх нэгтгэн дүгнэх сэтгэхүйн аналитик чадвар нь харьцангуй өндөр байна ( $P < 0.05$ ;  $M = 1.9$ ;  $M = 2.6$ ).

Хүснэгт 22. Бодит дүрслэлийн сэтгэхүй-задлан шинжлэх чадварт цэцэрлэгт хамрагдсан байдлын нөлөө, хувиар

		Задлан шинжлэх үйлдлийн түвшин					Бүгд
		маш сул	маш сул	сул	дундаж	сайн	
Үгүй	Цэцэрлэгт явсан эсэх	60.9%	4.3%	21.7%	8.7%	4.3%	100.0%
Тийм		25.0%	22.1%	27.9%	22.1%	2.9%	100.0%

Мөн хүүхдүүдийн гадаад шинжид нь тулгуурлан юмсыг ерөнхийд нь ойлгож сэтгэх чадварт нь хүүхдүүдийн **дугуйланд хамрагддаг** эсэх нь статистик ач холбогдлын түвшинд тодорхой хэмжээгээр нөлөөлжээ ( $P < 0.05$ ).

Дугуйланд хамрагддаг гадаад шинж байдалд нь тулгуурлан сэтгэх чадвар нь дугуйланд явдаггүй гэсэн хүүхдүүдтэй харьцуулахад 0.65-аар илүү түвшин байна ( $M=4.0$ ;  $M=4.65$ ).

Хүснэгт 23. Бодит дүрслэлийн сэтгэхүйн хөгжилд дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар

		Гадаад шинжид нь тулгуурлан сэтгэх сэтгэхүй				Бүгд
		маш сул	сул	дундаж	сайн	
Үгүй	Дугуйланд явдаг эсэх	15.7%	7.8%	21.6%	54.9%	100.0%
Тийм		5.0%	7.5%	5.0%	82.5%	100.0%

Дугуйланд хамрагддаг хүүхдүүдийн 83 хувь нь юмсын гадаад шинжид нь тулгуурлан сэтгэх чадвар сайтай байхад хамрагддаггүй хүүхдүүдийн 55 хувь нь тухайн түвшинд байгаа нь дээрх хүснэгтээс харахаар байна.

### 2.3.2. Орон зайн дүрслэлийн сэтгэхүй

Орон зайн дүрслэлийн сэтгэхүй гэдэг нь алив дүрс, хэлбэрийн бүтэц, зохион байгуулалт, дотоод холбоо хамаарлыг нь олж харах замаар зүй тогтлыг нь таних харьцуулах үйлдлийн үндсэн дээр явагдаж байгаа сэтгэхүйн үйлдэл юм.

Хүснэгт 24. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн орон зайн дүрслэлийн сэтгэхүйн даалгавруудын хүчин зүйлийн шинжилгээ

Даалгавар	Хүчин зүйлийн коэффициент			Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
	1	2	3	
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 1		.821		0.82
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 2		.689		
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 3		.708		
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 4		.508		



орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 5			.752
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 6			.603
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 7			.720
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 8	.794		
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 9	.678		
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 10	.664		
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 11	.763		
орон зайн дүрслэлийн сэтгэхүй даалгавар 12	.906		

Хүүхдүүдийн алив дүрс хэлбэрийн бүтэц, зохион байгуулалтыг таньж сэтгэх чадвар нь дундаж түвшинд байна (M=3.1)

Хүснэгт 25. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн орон зайн дүрслэлийн сэтгэхүйн статистик үзүүлэлт

	Бага утга	Их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Статистик утга	Стандарт алдаа	
Орон зайн дүрслэлийн сэтгэхүй түвшин	1	5	3.11	.098	.936

Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварыг сэтгэхүйн үйлдэл талаас нь авч үзвэл, хүүхдүүд юмсыг илэрхий энгийн буюу хүчин чармайлт бага шаардсан шинж чанарт нь тулгуурлан ялгаатай ба төсөөтэй талыг нь харьцуулан сэтгэх нь дунджаас бага зэрэг дээгүүр түвшинд байна (M=3.57).

Харин юмсын бүтцийн хоорондын холбоо хамаарал, зүй тогтол бүхий зохион байгуулалтыг нь хараад танин мэдэж нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл нь сул байна (M=2.04).

Хүснэгт 26. Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварын статистик үзүүлэлт

Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн үйлдэл	Бага утга	Их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Статистик утга	Стандарт алдаа	
энгийн шинжээр нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл	1	5	3.57	.156	1.484
зүй тогтол холбоо хамааралд нь сэтгэх сэтгэхүйн үйлдэл	1	5	2.04	.145	1.382

Хүүхдүүдийн **хөгжлийн бэрхшээлийн ялгаатай** байдлаас орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварын үзүүлэлт хамааралтай байлаа ( $p < 0.01$ )

Хүснэгт 27. Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварт бэрхшээлийн ялгаатай байдлын нөлөө, статистик үзүүлэлт

	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Between Groups	22.532	4	5.633	8.686	.000
Within Groups	55.123	85	.649		
Total	77.656	89			


Доорх зургаас харахад, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд юмсын энгийн хялбар шинж чанарыг таньж харьцуулан ялгаатай ба төсөөтэй талыг нь таньж нэгтгэн дүгнэх нь маш сайн, харин юмсын бүтэц бүрэлдэхүүний холбоо хамаарал, зүй тогтол, зохион байгуулалтыг нь таньж задлан шинжлэх нэгтгэн дүгнэх сэтгэхүйн чадвар нь сайн түвшинд байна (M=3.56).

Бие махбодын бэрхшээлтэй хүүхдүүд юмсын хялбар энгийн шинжийг нь харьцуулан ялгаатай ба төсөөтэй талыг нь олж нэгтгэн дүгнэх нь сайн харин зүй тогтол, зохион байгуулалтыг нь таньж нэгтгэн дүгнэх сэтгэхүйн чадвар нь сул түвшинд байна.

Харин зан төлөвийн бэрхшээлтэй буюу аутизмтай хүүхдүүдийн энгийн шинжийг нь таньж харьцуулан нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл нь дунджаас бага зэрэг дээгүүр, бүтэц бүрэлдэхүүний холбоо хамаарал, зүй тогтол, зохион байгуулалтыг нь таньж нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл нь сул байна.

Оюун ухааны хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүдийн энгийн шинжид нь тулгуурлан сэтгэх нь дундаж, харин зүй тогтолд нь сэтгэн бодох нь маш хангалтгүй байна.

Зураг 6. Орон зай дүрслэлийн сэтгэхүйн чадвар бэрхшээлийн төрлөөр, дундаж үзүүлэлтээр



**Цэцэрлэгт явсан эсэх** нь хүүхдүүдийн юмс үзэгдлийн энгийн хялбар шинжийг нь таньж, түүнд тулгуурлан ижил төстэй шинжээр нь харьцуулан нэгтгэн дүгнэх сэтгэхүйн чадварт статистик ач холбогдлын түвшинд нөлөөлжээ ( $p < 0.05$ ).

Цэцэрлэгт явсан хүүхдүүдийн юмсын шинж чанар дээр нь тулгуурлан ижил төстэй шинжээр нь нэгтгэн дүгнэх сэтгэхүйн чадвар нь дунджаас дээгүүр түвшинд (M=3.0) бол

яваагүй гэж хариулсан хүүхдүүдийнх дундаж түвшинд байлаа (M=3.8). Өөрөөр хэлбэл, цэцэрлэгт хамрагдаагүй гэж хариулсан хүүхдүүдийн дундаж ба сайн түвшинд нийт хүүхдүүдийн 39.1 хувь нь байгаа бол мөн тухайн түвшинд цэцэрлэгт явсан гэж хариулсан хүүхдүүдийнх 69 хувь нь байна.

Хүснэгт 28. Орон зайн дүрслэлийн сэтгэхүйн чадварт цэцэрлэгт хамрагдалтын нөлөө, хувиар

		энгийн шинжээр нэгтгэн дүгнэх сэтгэхүйн түвшин				Бүгд
		маш сул	сул	дундаж	сайн	
Үгүй	Цэцэрлэгт явсан эсэх	39.2%	21.7%	8.7%	30.4%	100.0%
Тийм		23.5%	7.4%	27.9%	41.2%	100.0%

Мөн **дугуйланд хамрагддаг** эсэх нь хүүхдүүдийн дүрс зургийн бүтэц, бүрэлдэхүүний хоорондын холбоо зүй тогтол, холбоо хамаарлыг нь таньж сэтгэх чадварт эерэг нөлөө үзүүлжээ ( $P < 0.05$ )

Дугуйланд хамрагддаг хүүхдүүдийн зүй тогтолд нь сэтгэх чадвар нь 0.3 нэгжээр илүү байна (M=1.76; M=2.04).

Хүснэгт 29. Орон зайн дүрслэлийн сэтгэхүйд дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар

		зүй тогтол холбоо хамааралд нь сэтгэх сэтгэхүйн түвшин					Бүгд
		Маш сул	Сул	Дундаж	Сайн	Маш сайн	
Үгүй	Дугуйланд явдаг эсэх	62.7%	13.7%	9.8%	11.8%	2.0%	100.0%
Тийм		47.5%	10.0%	12.5%	15.0%	15.0%	100.0%

Дээрх хүснэгтээс харахад, ойролцоогоор дугуйланд хамрагддаггүй 5 хүүхэд тутмын 3 нь сул түвшинд байхад дугуйланд хамрагддаг 3 хүүхэд тутмын 1 сайн түвшинд байна.

#### 2.3.4. Хийсвэр сэтгэхүйн хөгжлийн онцлог

Учир шалтгаан, зүй тогтолд нь юмсыг сэтгэх хийсвэр сэтгэхүйн хөгжлийг зураг харуулж зүй тогтлыг нь олох даалгавраар судаллаа. Даалгаврын гүйцэтгэлийн шинжилгээгээр найдвартай байдал нь цаашид боловсруулалт хийх боломжтой ба даалгавруудын гүйцэтгэлийн үзүүлэлт нь харилцан хамааралтай нэг багц бүрэлдэхүүнийг үүсгэсэн тул тохироцтой гэж үзлээ.

Хүснэгт 30. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйн даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ

Даалгавар	Хүчин зүйлийн коэффициент	Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
юмсын тоог таньж цифрээр төлөөлөх-тооны харьцуулалт	.662	0.67
Хөргөгчтэй харьцуулан плитка олох-хэрэглээ зориулалтаар нь харьцуулах	.671	
учир шалтгааныг нь таньж 2 жимс олох хэмжээг харьцуулах	.864	
Хүрз-халбага аль нь урт болох - үг зүйг таних харьцуулалт-хийсвэрлэх	.618	

Дээрх хүснэгт дэх хүчин зүйлийн шинжилгээнээс харахад, хийсвэр сэтгэхүйн хөгжилд хамгийн чухал нөлөөтэй үйлдэл нь юмсын учир шалтгаан зүй тогтлыг нь хийсвэрлэн таних чадвар байна. Иймд хүүхдүүдийн тухайн чадварыг сургалт хөгжлийн үйл ажиллагаагаар дэмжих нь хийсвэр сэтгэхүйн хөгжлийг бүхэлд нь хөгжүүлэхэд гол үүрэгтэй ажээ.


Хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйн хөгжил нь дундаж түвшинд байна (M=2.9). Хөгжлийн бэрхшээлийн ялгаатай байдлаас хамаарсан статистик ялгаа алга байна.

Хүснэгт 31. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйн с татистик үзүүлэлт

	Бага утга	Их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Статистик утга	Стандарт алдаа	
Хийсвэр сэтгэхүй	1	5	2.89	.115	1.112

Даалгаврын гүйцэтгэлээр нь үзвэл, хүүхдүүд юмсын олон цөөн гэх мэт тоог таньж цифрээр төлөөлүүлэх даалгаврыг 63 хувь нь гүйцэтгэсэн бол юмсын хэрэглээ зориулалтаар нь гол шинжийг нь харьцуулан хийсвэрлэх даалгаврыг 20 хувь нь л оновчтой гүйцэтгэжээ. П

Зураг 7. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйн чадвар, хувиар



Даалгаврын гүйцэтгэлээс үзэхэд, хүүхдүүд юмсын гол шинжийг харьцуулан хийсвэрлэх чадвартай боловч мэдээлэл нь нарийсах тусам энэ чадвар хангалтгүй байна. Жишээлбэл, хөргөгчийн шинж чанарыг харьцуулан плитка олох даалгаврыг хөргөгч, зайрмаг 2-ыг шууд харьцуулсан нь хүүхдүүдийн бараг 50 хувьд нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, хүүхдүүдэд хөргөгч гэхээр дотор нь хийх, хүйтэн байх гэсэн сэтгэхүйн холбоос үүсэж сонголтыг хийж байгаа нь хийсвэрлэх чадвар хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Мөн хүрз, халбага 2-ын аль нь урт болохыг үгийг харуулаад асуухад 35 хувь нь хүрз гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, үгийн бүтцэд бус үгээр илэрхийлэгдэж байгаа юмсын бодит хэмжээ хэлбэрийг чухалчилжээ. Мөн 2 жимс, 2 шар шувууны зургийг хараад 2 ширхэг гүзээлгэнэ олох даалгаврыг гүйцэтгэхдээ нэг шар шувуу, нэг хэрмийг 50 хувь нь сонголт хийжээ. Хүүхдүүд тоо ширхэг дээр нь анхаарал хандуулахгүйгээр зөвхөн адилтгаж шар шувууг сонгох эсвэл хэрэм байхгүй байна гэж тусгаж сонголтыг хийсэн нь юмсын гол шинжийг нь харьцуулах хийсвэр сэтгэхүйн чадвар хангалтгүй ба бодит дүрслэлийн сэтгэхүй, харагдаж буй шинж байдлаар нь харьцуулах сэтгэхүй танин мэдэхүйд давамгайлдгийг илэрхийлж байна.

### Дүгнэлт: Сэтгэхүйн чадварын онцлог

Хүүхдүүд юмсыг харагдаж байгаа шинж байдлыг хооронд нь харьцуулан адилтгах замаар сэтгэдэг онцлогтой байна. Харин юмсын түүнийг бүрдүүлэгч хэсгүүдэд нь задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвар хангалтгүй, өөрөөр хэлбэл, бүхэл зүйлээс элементийг ялган сэтгэх, бүтцийг бүхэл болгож нэгтгэх, нийтлэг шинжид нь тулгуурлан нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл харьцангуй сул байна. Юмс үзэгдлийн хоорондын холбоо хамаарал, зүй тогтлыг нь танихдаа гадаад шинж байдлын ижил төстэй шинжээр нь адилтгадаг бодит сэтгэхүйн шинж давамгайл байна.

Хүүхдүүдийн сэтгэхүйн хөгжил бэрхшээлийн ялгаатай байдал, хичээлээс гадуурх дугуйлан, секцэд хамрагддаг эсэх, сургуульд орохоос өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан эсэх нь статистик ач холбогдлын түвшинд нөлөөлжээ ( $p < 0.01$ ).

Сонголын бэрхшээлтэй хүүхдүүдийн задлан шинжилж нэгтгэн дүгнэх үйлдэл нь харьцангуй эерэг түвшинд байна.

Дугуйлан секцэд хамрагддаг болон цэцэрлэгт явж байсан хүүхдүүдийн сэтгэхүйн чадвар нь харьцангуй эерэг түвшинд байна.

#### 2.4. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог

Хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг “Люшерийн өнгөний сорилын аргаар судаллаа.

Судалгаагаар хүүхдүүдийн зан төлөвийн ерөнхий онцлог, гэр бүл, сургуульдаа хандах хандлага, сэтгэл санааны байдал, идэвхтэй байдлыг илрүүлэх зорилго тавилаа.

##### 2.4.1. Зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөний ерөнхий онцлог

Зан төлөвийн онцлогийг таалагдаж байгаа өнгөний сонголтоор тодорхойлохыг зорилго.

Даалгаврын гүйцэтгэл нь харилцан хамааралтай багц бүрэлдэхүүнийг үүсгэж байгаа тул хүүхдүүдийн зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөний онцлогийг тодорхойлохуйц бөгөөд найдвартай чанарын үзүүлэлт нь статистик хангалттай байдлыг илэрхийлж байна.

Хүснэгт 32. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөө, зан төлөвийн даалгаврын хүчин зүйлийн шинжилгээ

Даалгавар	Хүчин зүйлийн коэффициент		Найдвартай байдлын коэффициент (Кронбах Альфа)
	1	2	
Норматив өнгө байрлал 1 -Улаан	.439		0.76
Норматив өнгө байрлал 2 - Шар		.698	
Норматив өнгө байрлал 3-Ногоон	.726		
Норматив өнгө байрлал 4 - нил ягаан	.634		
Норматив өнгө байрлал 5 - Цэнхэр		.833	
Норматив өнгө байрлал 6 - Бор	.725		
Норматив өнгө байрлал 7-Саарал	.514		
Норматив өнгө байрлал 8-Хар	.652		

Хүүхдүүдийн хийсэн сонголтоос харахад хамгийн эхэлж улаан өнгийг 21 хувь нь, шар өнгийг 18 хувь нь, 21 хувь нь ногоон, цэнхэр өнгийг сонгожээ.

Хоёр дахь дахь байрлалд 31 хувь нь улаан өнгийг, 17 хувь нь ногоон өнгийг, 13 хувь нь шар өнгийг сонгожээ.


Гуравт нь улаан өнгийг 25 хувь нь, шар өнгийг 26 хувь нь, нил ягаан өнгийг 15 хувь нь сонгожээ.

Зан төлөвийн хувьд ерөнхийдөө хөдөлгөөнтэй, хөгжилтэй өөдрөг, заримдаа тэвчээргүй, амархан уурлах бухимдах мөн магтуулах дуртай зан төлөв ажиглагдлаа.

Зан төлөвийн ерөнхий онцлогийн хувьд хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарсан үзүүлэлт алга байна.

Сэтгэл санааны байдал нь нийт хүүхдүүдийн хувьд сул байна ( $M=2.3$ ). Хүүхдүүдийн 50 хувь нь сэтгэл санааны хувьд сул түвшинд байна. Иймд сөрөг сэтгэлийн хөдөлгөөнд амархан автагддаг. Онцгүй сэтгэл санааны байдал, санаа зоволттой тул хүүхдүүдийн сэтгэл санааны байдалд соргог хандаж, учир шалтгааныг нь илрүүлэхийг эрмэлзэх нь зүйтэй юм. Сургуулийн дасан зохицолт хангалтгүй, сурч байгаа үедээ олон бэрхшээлтэй асуудлууд санааг нь зовоодог хандлагатай. Эдгээр нь хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарсан статистик ялгаа ажиглагдсангүй.

Зураг 8. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэл санааны байдлын түвшин, хувиар



Хүснэгт 33. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний түвшин, статистик үзүүлэлт

	Бага утга	Их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Статистик утга	Стандарт алдаа	
сэтгэлийн хөдөлгөөний онцлог	1	5	2.33	.115	1.111

**Дугуйланд хамрагддаг эсэх нь** хүүхдүүдийн сэтгэл санааны байдалд статистик түвшинд нөлөөлсөн байна ( $p<0.01$ ).


Хичээлээс гадуур дугуйлан секцэд хичээллэдэг гэж хариулсан хүүхдүүдийн сэтгэл санааны байдал нь хичээллэдэггүй хүүхдүүдтэй харьцуулахад сэтгэл санааны байдал тааруухан

санаа зоволт өндөр байгаа нь багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эхчүүдийн анхаарал хандуулах нэг тал болж байна.

Хүснэгт 34. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний онцлогт дугуйланд хамрагдалтын нөлөө, статистик үзүүлэлт

	Дугуйлан явдаг	Дундаж /Mean	Стандарт хазайлт	Стандарт алдаа
сэтгэлийн хөдөлгөөний онцлог	тийм	1.97	.986	.158
	үгүй	2.58	1.134	.153

Зураг 9. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний онцлогт дугуйланд хамрагдалтын нөлөө, хувиар



Дээрх зургаас харахад, дугуйланд хамрагддаг 5 хүүхэд тутмын 3 нь сэтгэл санааны хувьд тавгүй, дарамттай байдаг байна.

#### 2.4.2. Сэтгэлийн хөдөлгөөний эрч хүчтэй байдал


Сэтгэлийн хөдөлгөөний эрч хүчтэй байдал нь хүүхдүүдийн ачааллыг даах чадварыг илэрхийлдэг ба судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд энэ нь дунджаас бага зэрэг дээгүүр түвшинд байна. Эндээс харахад хүүхдүүд эрч хүчтэй, сэтгэл хөдлөл өндөр, мэдрэлийн хувьд ядрах нь бага байдал харагдаж байна.

Мөн 29 хувь нь дундаж түвшинд байгаа тул хэт ядрахаас сэргийлэх, ачааллыг зохицуулахад анхаарах нь зүйтэй юм.

Хүснэгт 35. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний эрч хүчтэй байдал, статистик үзүүлэлт

	Бага утга	Их утга	Дундаж үзүүлэлт		Стандарт хазайлт
			Статистик утга	Стандарт алдаа	
эрч хүчтэй байдлын түвшин	1	5	3.61	.072	.701

Зураг 10. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний түвшин, хувиар



### **Дүгнэлт: Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог**

Сэтгэлийн хөдөлгөөний хувьд хүүхдүүд сэтгэл санааны байдал нь сөрөг, санаа зоволт өндөр, ачааллыг даах чадвар сайтай, эрч хүчтэй байдал ажиглагдлаа. Ерөнхийдөө энэ нь бүх хүүхдүүдийн хувьд жигд, бэрхшээлийн ялгаатай байдлаас хамаардаггүй байна.

Зан төлөвийн хувьд хөдөлгөөнтэй, хөгжилтэй, заримдаа тэвчээргүй загнах талтай, амархан уурлан бухимдах, баярлах гэх мэтээр зан төлөв нь тогтворгүй, магтуулах дуртай байна. Зан төлөв нь мөн бэрхшээлийн ялгаатай байдлаас хамаараагүй. Харин хичээлээс гадуурх дугуйлан секцэд хамрагддаг эсэх нь хүүхдүүдийн сэтгэл санааны байдалд сөргөөр нөлөөлсөн нь анхаарал татууштай дүр зураг байлаа ( $p < 0.01$ ). Өөрөөр хэлбэл, дугуйлан секцэд хамрагддаг байх тусам хүүхдүүд илүү санаа зоволт өндөр байна. Мэдээж үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь бусдын шийдвэрээр дугуйлан секцэд явж байгаа, мөн сургалтын явцад ялгаатай байдлаа мэдэрдэгтэй холбоотой байх бүрэн боломжтой юм.

### **Гурав. Тусгай хэрэгцээт боловсролын хүүхдүүдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөний чадварын ерөнхий онцлог**

#### **3.1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог**

##### **3.1.1. Танин мэдэхүйн хөгжлийн онцлог**

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүүд нь юмс үзэгдлийг харагдаж байгаа гадаад шинж байдалд нь тулгуурлан ижил төстэй болон ялгаатай талыг нь харьцуулах, харагдаж байгаа ижил төстэй шинжээр нь адилтгаж нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл давамгайлдаг тул бодит дүрслэлийн сэтгэхүй сайтай байна.


Харин юмс үзэгдлийг түүнийг бүрдүүлэгч элементэд нь задалж сэтгэх буюу бүхлээс хэсгүүдэд хувааж сэтгэх, юмсын учир шалтгаан, зүй тогтлыг нь таних сэтгэхүйн үйлдлийг нь дэмжих хэрэгцээтэй байна. Ийнхүү дэмжихдээ бүхэлд нь юмсыг ерөнхий байдлаар харагдаж байгаа илэрхий шинжид тулгуурлан сэтгэдэг онцлогт нь задлан шинжлэх чадварыг нь тодорхой арга зүйгээр хөгжүүлэх нь зүйтэй юм.



Ийнхүү сэтгэхүйн хувьд бүхлийг түүнийг бүрдүүлэгч хэсгээс задалж ойлгохдоо бэрхшээдэг тул харааны хүртэхүйн хувьд жижиг бүтэц хэсгийг хүртэж ойлгох нь хангалтгүй зөвхөн бүхэлд нь ерөнхийд нь хүртдэг тал харагдаж байна.

Хүүхдүүд анхаарлаа төвлөрүүлэн хүчин чармайлт бага шаардсан үйлдлийг гүйцэтгэхдээ хурдтай боловч хялбар ядарч, анхаарал сарнин бүтээмж буурах талтай. Богино хугацаанд энгийн дүрс зургийг хараад 7-8 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг.


Зураг 11. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадваруудын түвшин, дундаж үзүүлэлтээр




### 3.1.2. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд сэтгэл санааны байдал нь өөдрөг бус, санаа зоволт өндөр, сэтгэл хөдлөлийн хувьд амархан уурлаж бухимдах, баярлах гэх мэт тогтворгүй байдал давамгайлдаг. Зан төлөвийн хувьд сэргэлэн цовоо, идэвхтэй, хөдөлгөөнтэй шинж давамгайлж байна. Заримдаа тэвчээргүй зантай.

Зураг 12. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр




Зураг 13. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, түвшингээр, хувиар



Дээрх зургаас харахад, хүүхдүүдийн 65 хувь нь сэтгэл санааны хувьд таагүй, санаа зоволт өндөртэй байгаа нь анхаарал анхаарал хандуулах шаардлагатай байна.

Зураг 14. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн идэвхтэй шинж, түвшин, хувиар



### 3.2. Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог (Аутизм)


#### 3.2.1. Танин мэдэхүйн хөгжлийн онцлог

Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн гол онцлог нь юмсыг хараад түүнийг харагдаж байгаа гадаад шинжээр нь харьцуулан ижил төстэй ба нийтлэг шинжийг олох ерөнхийд нь бүхэлд нь харж сэтгэдэг, нэгтгэн дүгнэдэг онцлогтой ба тэдгээрийг бүрдүүлэгч бүтэц элементийг ялгаж сэтгэх, тэдгээрийн хоорондын зүй тогтол холбоо хамаарлыг нь олж харах нь сул байдаг байна.

Харж хүртэхдээ ерөнхийд нь хүртдэг онцлогтой, бүрдүүлэгч хэсгүүдийг ажиглан хүртэх нь хангалтгүй, өөрийн дуртай зүйлдээ анхаарлаа төвлөрүүлэх боловч зориудаар анхаарлаа төвлөрүүлэн ажиллах нь бэрхшээлтэй, хурд нь хангалтгүй боловч анхаарлыг нь татаж сонирхолтой бол анхаарал нь сарних нь бага байдаг байна.

Богино хугацаанд дүрс зургийг хараад ойролцоогоор 6-8 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг бол сонсоод 3-4 хүртэлх үгийг тогтоож сэргээн санадаг.


Зураг 15. Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварууд, дундаж үзүүлэлтээр




### 3.2.2. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог

Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн хувьд, сэтгэл санааны байдал нь тогтворгүй, хялбархан сэтгэл санаагаар унаж, эсхүл баярладаг. Зан төлөвийн хувьд мөрөөдөмтгий, хийсвэрлэн төсөөлөх нь их, идэвх сул, мэдрэмтгий, тайван зантай байх нь бий.

Зураг 16. Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр




Зураг 17. Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, хувиар



Дээрх зургаас харахад, 5 хүүхэд тутмын 2 нь сөрөг сэтгэл хөдлөл давамгай, санаа зоволт өндөр байна.

Зураг 18. Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн онцлог, хувиар



Дээрх зургаас харахад, зан төлөвийн хувьд идэвхтэй, аливаа зүйлд сонирхолтой ханддаг, хөдөлгөөнтэй, баярлах нь ч уурлах нь ч хялбар байдаг. Иймд сонирхлыг нь өдөөж үйл ажиллагаанд татан оролцуулвал хүүхэд идэвхтэй, ачааллыг даах чадвартай байна. Үүний зэрэгцээ хүүхдийн ажил амралтыг зөв зохицуулах нь чухал байна. Тийм бус тохиолдолд хүүхэд амархан ядрах, сонирхол нь хялбар буурах хандлагатай нь харагдаж байна.

### 3.3. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог


#### 3.3.1. Танин мэдэхүйн хөгжлийн онцлог

Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлог нь юмсыг бүтэц бүрэлдэхүүн, дэс дараалалд нь ажиглан хүртэх нь сайн. Юмсын гадаад шинж байдлыг нь ажиглан хооронд нь харьцуулан ижил төстэй ба ялгаатай талыг нь олох, түүнийг ерөнхий шинжээр нь нэгтгэн ойлгох чадвартай. Харин бүтэц бүрэлдэхүүнд нь задлан шинжилж нэгтгэн дүгнэх буюу бүхлийг түүнийг бүрдүүлэгч хэсгээс нь ялгаж ойлгох нь сул. Юмсыг ангилахдаа энгийн хялбар шинжийг нь авч үзнэ. Мөн чанар, дотоод холбоо хамаарал, зориулалт зэргээр нь ангилах чадвар хангалтгүй. Танин мэдэхүүд бодит сэтгэхүй давамгайлдаг ба хийсвэр сэтгэхүйн хөгжил сул байна.

Хүүхдүүдийн анхаарлын төвлөрөл дундаж түвшинд буюу зориудаар анхаарлаа төвлөрүүлэх нь заримдаа тодорхой хэмжээний хүчин чармайлтыг шаарддаг буюу анхаарлаа төвлөрүүлэн ажиллахдаа ядрах нь харьцангуй бага, жигд хэмнэлээр ажилладаг байна.

Хүүхдүүд харж энгийн дүрс, мэдээллийг харж тогтоохдоо богино хугацаанд ойролцоогоор 5-7 хүртэлх тэмдэгтийг тогтоож сэргээн санадаг бол богино хугацаанд үгийг сонсоод 4-5 үгийг тогтоож сэргээн санаж байгаа нь харьцангуй сул үзүүлэлт байлаа.


Зураг 19. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварууд, дундаж үзүүлэлтээр




### 3.3.2. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог

Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн хувьд сэтгэл санааны хувьд сөрөг, санаа зоволттой байдал давамгайлдаг, ачааллыг даах, эрч хүчтэй, идэвхтэй байдал давамгайлдаг ч зарим тохиолдолд амралтаа зохицуулж ачааллыг зохицуулж байх нь чухал юм. Ажилсаг, заримдаа тэвчээргүй зантай байх нь бий.

Зураг 20. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр




Зураг 21. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, хувиар



Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд тутмын нэг нь сөрөг сэтгэл хөдлөл давамгайл, санаа зоволт ихтэй байдаг байна.

Зан төлөвийн хувьд, 60 хувьд идэвхтэй, өөдрөг байгаа бол 33 хувь нь нөхцөл байдлаас үүдэн сэтгэл санаа нь өөрчлөгдөх, урам зориггүй болох, идэвхгүй болох хандлага ажиглагдлаа.

Зураг 22. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн онцлог, хувиар



### 3.4. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог

#### 3.4.1. Танин мэдэхүйн хөгжлийн онцлог

Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн гол онцлог нь юмсын гадаад шинж байдлыг харьцуулан адилтгаж ойлгодог, энгийн гадаад шинжээр нь харьцуулан нийтлэг шинжээр нь нэгтгэн дүгнэх нь хүчин чармайлтыг нэлээд шаарддаг, юмсыг бүтэц бүрэлдэхүүнд нь задлан шинжлэх нь сул, алив зүйлийг адилтгаж сэтгэдэг, харин юмсын учир


шалтгаан зүй тогтлыг таних нь маш сул байна. Өөрөөр хэлбэл хийсвэр сэтгэхүйн хөгжил маш сул.

Юмсыг харж хүртэхдээ ерөнхий дүр төрхийг нь хүртэж ойлгодог, харин бүтэц, бүрэлдэхүүн тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, дэс дараалал зэргийг ажиглан хүртэх нь хангалтгүй.

Анхаарлаа төвлөрүүлэн хүчин чармайлт бага шаардсан зүйлийг гүйцэтгэх чадвартай ч анхаарлын төвлөрөл хялбархан суларч ажиллах хурд хэмнэл нь удааширдаг. Иймд ачааллыг нь зохицуулах нь чухал юм. Зориудаар анхаарлаа төвлөрүүлэх нь хүүхдээс нэлээд хүчин чармайлт шаарддаг.

Ой тогтоолтын хувьд харж мэдээллийг тогтоохдоо богино хугацаанд энгийн дүрс зураг 5-6 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг бол үгийг сонсоод зориудаар 4-5 хүртэлх үгийг тогтоож сэргээн санадаг байна .


Зураг 23. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварууд, дундаж үзүүлэлтээр




### 3.4.2. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог

Оюун ухааны хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд сэтгэлийн хөдөлгөөний хувьд баяр хөөртэй, эерэг хандлагатай, сэтгэл санааны байдал нь баяр хөөртэйгөөс гуних гэх мэт амархан өөрчлөгддөг. Шинэ орчинд дасан зохицоход дэмжлэг хэрэгтэй. Ачааллыг даах чадвартай, эрч хүчтэй, идэвхтэй. Хөдөлгөөнтэй, хөгжилтэй, өөдрөг зантай, тэвчээргүй байдал гаргах нь бий. Мөрөөдөмтгий хүсэл мөрөөдөлтэй, гэхдээ үйл ажиллагаанд бэлэн биш байх нь бий. Анхаарлын төвд байх, бусдаас халамж анхаарал хүсдэг, магтуулах дуртай, амжилт гаргах эрмэлзэлтэй тул тухайн онцлогт нь тулгуурлан үйл ажиллагаанд өдөөх нь чухал юм.

Зураг 24. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог, дундаж үзүүлэлтээр




Зураг 25. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл санааны байдал, хувиар



Дээрх зургаас харахад оюуны бэрхшээлтэй 7 хүүхдэд тутмын 2 нь сөрөг сэтгэл хөдлөл давамгай, онцгүй сэтгэл санааны байдал, санаа зоволт давамгай байна. Энэ нь шинэ орчин нөхцөлд дасан зохицоход нь сөргөөр нөлөөлөх талтай.

Зан төлөвийн хувьд, 62 хувь нь идэвхтэй, ачааллыг даах чадвартай байна. Харин 32 хувь нь идэвх, сонирхол нь амархан буурах хандлагатай байна.

Зураг 26. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн зан төлөвийн онцлог, хувиар





## ДҮГНЭЛТ

- **Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлог**

### Танин мэдэхүйн хөгжлийн онцлог

Танин мэдэхүйн хувьд, бодит дүрслэлийн сэтгэхүй давамгайлдаг ба үзэгдэл юмсыг хооронд нь харьцуулан адилтгаж ойлгодог ба харин бүтэц бүрэлдэхүүнд задлан шинжилж нэгтгэн дүгнэхдээ бэрхшээдэг талтай.

Харааны хүртэхүйн хувьд ерөнхий дүр байдлыг нь хүртээд, жижиг бүтэц бүрэлдэхүүн, тэдгээрийн хоорондын ялгаатай болон ижил төстэй байдлыг нь харж хүртэхдээ өнгөц хандах талтай.

Анхаарлын төвлөрөл шаардсан энгийн зүйлийг хурдтай гүйцэтгэх боловч хялбархан ядарч анхаарал нь сарнин, бүтээмж нь буурах магадлалтай. Богино хугацаанд энгийн дүрс зургийг хараад 7-8 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг онцлогтой байна. Өөрөөр хэлбэл, мэдээллийг харж тогтоох, анхаарал шаардсан энгийн үйлдлийг эхлээд хурдтай гүйцэтгэж байснаа сонирхол нь буурах юмуу ядраад анхаарал нь сарнидаг, хүчин чармайлт бага шаардсан мэдээллийг нийтлэг шинжээр нь нэгтгэн дүгнэдэг онцлог давамгайл байна.

### Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог

Сэтгэлийн хөдөлгөөний хувьд, баярлах, уурлаж бухимдах нь амархан, өөдрөг бус, санаа зоволт өндөртэй байна.

Зан төлөвийн хувьд сэргэлэн цовоо, идэвхтэй, хөдөлгөөнтэй, заримдаа тэвчээргүй загнах нь бий. Ялангуяа маш амархан ядрах, цочирдон уурлах хандлагатай байна. Энэ нь хүүхдүүдийн мэдээллийг тогтоох, анхаарлаа төвлөрүүлэх чадварт нь сөргөөр нөлөөлдөг байх магадлал өндөр юм.

- **Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлог**

### Танин мэдэхүйн хөгжлийн онцлог

Танин мэдэхүйн хувьд, гадаад шинж байдлаар юмсыг харьцуулах чадвартай, харин юмсыг бүтэц бүрэлдэхүүнд нь задлан шинжилж, нэгтгэн дүгнэх чадвар хангалтгүй байна. Юмсын шинж байдлыг адилтган учир шалтгааныг нь олохдоо сайн, харин зүй тогтол, мөн чанараар нь хийсвэрлэн сэтгэх нь харьцангуй сул байна.

Мэдээллийг харж хүртэхдээ жижиг бүтэц бүрэлдэхүүнийг нь ажиглах нь харьцангуй сул, бүхэлд нь илэрхий зүйлийг л ажигладаг. Зориудаар анхаарлаа төвлөрүүлэн ажиллахдаа бэрхшээдэг, өөрийн сонирхол татсан зүйлдээ анхаарал нь төвлөрүүлэх нь илүү, энэ тохиолдолд анхаарал нь сарних нь харьцангуй бага байна. Богино хугацаанд дүрс зургийг хараад ойролцоогоор 6-8 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг бол үгийг сонсоод богино хугацаанд 3-4 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг онцлогтой.

### Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог

Сэтгэлийн хөдөлгөөний хувьд сэтгэл санаа нь тогтворгүй, баярлах гомдох нь хялбар. Мөрөөдөмтгий, юмсыг хийсвэрлэн төсөөлөх дуртай, мэдрэмтгий, тайван үг дуу цөөтэй байх нь бий.

Насанд хүрэгчдийн зүгээс ялангуяа, эцэг эхийн зүгээс хүүхдийг хэт шахалт дарамт үзүүлэх, эсвэл хэт бөөцийлөн харилцах нь тэднийг уурлан бухимдуулах шалтгаан болох нь бий. Ингэснээр хүүхэд үйл ажиллагаанд маш амархан идэвхгүй болох талтай.

➤ **Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлог**

**Танин мэдэхүйн хөгжлийн онцлог**

Танин мэдэхүйн хувьд, юмсыг харагдаж байгаа гадаад шинж байдлаар нь харьцуулан ялгаатай ба төсөөтэй талыг нь олж сэтгэх, юмсын бүтэц бүрэлдэхүүнийг ажиглан хүртэх нь сайн, учир шалтгаанд нь сэтгэх, анхаарлаа зориудаар төвлөрүүлэн ажиллах, учир шалтгаан холбоо хамааралд нь сэтгэх нь хүчин чармайлт шаарддаг буюу юмсыг адилтгах замаар сэтгэдэг онцлогтой, сонирхолтой зүйлдээ анхаарлаа төвлөрүүлэн ажиллахдаа анхаарал сарних нь харьцангуй багатай.

Харж мэдээллийг тогтоохдоо богино хугацаанд ойролцоогоор 5-7 хүртэлх дүрс зургийг тогтоож сэргээн санадаг бол үгийг сонсоод богино хугацаанд 4-5 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг онцлогтой ажээ.

Юмсыг бүтэц бүрэлдэхүүнд задлан шинжилж нэгтгэн дүгнэх чадвар харьцангуй сул байна.

**Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог**

Сэтгэл санааны хувьд санаа зоволт өндөртэй, эрч хүчтэй боловч заримдаа ачааллаа зохицуулахад зайлшгүй анхаарах нь чухал. Ажилсаг, идэвхтэй ч нөхцөл байдлаас хамааран тухайн байдал нь амархан буурдаг тал ажиглагдлаа.

➤ **Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлог**

**Танин мэдэхүйн хөгжлийн онцлог**

Юмсыг гадаад харагдаж байгаа шинж байдлаар нь харьцуулах сэтгэхүйн үйлдэл танин мэдэхүйд нь давамгайлдаг. Учир шалтгаанд нь сэтгэх, юмсын бүтэц бүрэлдэхүүнийг ажиглан хүртэхдээ бэрхшээдэг буюу бүхэлд нь хүртэх талтай, анхаарлаа зориудаар төвлөрүүлэх нь хангалтгүй харин сонирхолтой хялбар зүйлд анхаарлаа төвлөрүүлэн ажилладаг ч анхаарал нь хялбар сарних магадлалтай.

Сэтгэхүйн хувьд бүтэц бүрэлдэхүүнд нь задлан шинжлэх, юмсын зүй тогтол холбоо хамаарлыг нь олж нэгтгэн дүгнэх үйлдэл харьцангуй сул. Энгийн харагдаж байгаа шинж байдалд нь тулгуурлан нийтлэг шинжээр нь нэгтгэн дүгнэх чадвартай ч энэ нь дэмжлэг хүчин чармайлтыг шаарддаг байна.

Дүрс зургийг харж тогтоохдоо 5-6 хүртэлхийг сэргээн санадаг бол үгийг сонсож тогтоохдоо 4 -5 хүртэлх үгийг сэргээн санадаг онцлогтой.

**Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог**

Сэтгэлийн хөдөлгөөний хувьд, баяр хөөртэй, хөгжилтэй, эерэг хандлагатай ч сэтгэл санаа нь амархан өөрчлөгддөг. Зан төлөвийн хувьд, хөдөлгөөнтэй, мөрөөдөмтгий анхаарлын төвд байх дуртай, бусдаас хайр халамж, магтаал хүсдэг, амжилт гаргах эрмэлзэлтэй байна.

Маш амархан ядрах, цочирдон уурлах хандлагатай байна. Энэ нь хүүхдүүдийн мэдээллийг тогтоох, анхаарлаа төвлөрүүлэх чадварт нь сөргөөр нөлөөлдөг байх магадлал өндөр юм.

## **Зөвлөмж**

- **Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлогийг дэмжих**

### **Танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг дэмжих**

- Анхаарлаа төвлөрүүлэн үйлдлийг гүйцэтгэхдээ хялбархан анхаарал сарних, ядрах, сонирхол буурах нь амархан тул ойрхон анхаарлыг нь татах, завсарлага авах, хүүхдийн сонирхлыг явц дунд нь татах үйлийг ойр ойрхон хийх нь зүйтэй юм.
- Энгийн дүрс зурган тэмдэглэгээгээр мэдээллийг кодлох замаар ой тогтоолт, анхаарлын чадварыг нь дэмжих нь үр дүнтэй. Нэг удаад өгөх тэмдэгт, дүрсийн тоо 7-8 байх ба аажмаар тоог нь нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй юм. Богино хугацаанд тоо/цифр, үгсийг тогтоох чадварыг нь дэмжихдээ эхний ээлжинд 3-4 байх аажмаар тоог нь нэмэгдүүлэх
- Сэтгэн бодох үйл ажиллагааг дэмжихдээ бодит дүрслэлийн сэтгэхүүд нь тулгуулах: Үүний тулд:
  - Алив мэдээллийг бүхэлд нь дүрсэлж ойлгуулаад дараа нь бүтцэд задалж тайлбарлах, ийнхүү тайлбарлахдаа ал болох хийсвэр ойлголтоос зайлсхийж мэддэг зүйлтэй нь холбож ойлгуулах
  - Юмсын бүтэц, бүрэлдэхүүнийг сайтар ажиглуулах, олуулах үйлдлийг тогтмол хийх,
  - Юмсын бүтэц бүрэлдэхүүн, жижиг хэсгийг ажиглуулан нэрлүүлсний дараа ерөнхийд нь нэрлүүлэх гэх мэт нэгтгэх үйлдлийг хийлгэх
  - Хичээл сургалтын явцад алив эх/тексийн агуулгыг дүгнэх, сэдвийн гарчигтайгаа яаж холбогдож байгааг задлан шинжилж ярилцах, хүүхдээр яриулах, эссэ, шүлэг эх зохиолгох үйлийг тогтмол хийх, оновчтой дүгнэлт хийх чадварыг ямагт дэмжих нь үр дүнтэй байна.
  - Юмсын хоорондын ижил төстэй, ялгаатай байдлыг зүй тогтол, учир шалтгааны үүднээс олох үйлдлийг хичээлийн арга зүй болгох, ийнхүү дэмжихдээ эхлээд энгийн дүрс зургийн зүй тогтлыг оновчтой олох чадварыг дэмжих

### **Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг дэмжих**

Багш, эцэг эхчүүд хүүхэдтэй харилцахдаа нээлттэй илэн далангүй, нөхөрсөг харилцах тал дээр байнга анхаарал тавих, сэтгэл санааны тааламжгүй байдалд нь соргог хандах, учир шалтгааныг олохыг эрмэлзэх, дэмжлэг зөвлөгөө үзүүлэх сургуульдаа дасан зохицох найз нөхдийн дунд санаа зовних асуудал байдаг тул тэднийг дэмжсэн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд анхаарах

Нийгмийн орчинд дасан зохицох үйл явцыг дэмжихийн тулд:

1. Танин мэдэхүйн хөгжлийг нь дэмжсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах
2. Иргэний чадварыг дэмжихэд үйл ажиллагааг чиглүүлэх (Бусадтай зөв харилцах, бодол санаагаа зөв оновчтой, илэн далангүй илэрхийлдэг нээлттэй зан төлөвийг нь дэмжих, өөртөө итгэлтэй байх, өөрийн сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвөө мэдэж зохицуулах, хүсэл эрмэлзэл зорилготой байх зан чанарыг хөгжүүлэх)
3. Хүүхэд маш амархан ядрах, бухимдах талтай тул ачааллыг нь тохируулахад анхаарах
4. Гоо зүйн мэдрэмжийг нь дэмжих замаар сэтгэлийн хөдөлгөөний чадварыг дэмжих

➤ **Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлогийг дэмжих**

**Танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг дэмжих**

- Юмсын бүтэц, бүрэлдэхүүнийг ажиглах ажигч чанарыг нь дэмжих, үүний тулд анхаарлын төвлөрлийг нь дэмжих
- Хүүхдийн сонирхол татахуйц дүрс зургийг хичээлийн явцад тогтмол хэрэглэх, эхлээд бүхэл ерөнхий байдлаар нь ойлгуулаад дотроо юу юунаас бүрдэж байгааг нь хэлүүлэх гэх мэтээр ажиллах
- Юмсыг адилтгаж ойлгох, учир шалтгааныг нь хэлүүлэх замаар сэтгэхүйн чадварыг нь дэмжих, аажмаар аль болох зүй тогтлыг нь олох чадварыг дэмжих-Үүний тулд хүүхдээр аль болох юмсын хороодын уялдаа холбоог нь яриулах, үлгэр, өгүүллэг уншиж өгөх, яриулах гэх мэтээр дэмжих. Аль болох дүрс зургаар харуулах, төлөөлүүлэх аргыг хэрэглэх
- Үгийг тайлбарлах ойлгуулахдаа нэг удаадаа 3-4 хүртэлх байх, аажимдаа тоог нь нэмэгдүүлэх
- Дүрс зураг хэлбэрээр мэдээлэл тогтоолгохдоо нэг удаад 8 хүртэлх байх, аажмаар тоог нэмэгдүүлэхэд анхаарах

**Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг дэмжих**

Сэтгэлийн хөдөлгөөний хувьд тогтворгүй байх тул дүрэм журмыг ойлгуулахад анхаарал, хүүхэдтэй сайтар ярилцаж биеэ хэрхэн авч явах талаар ойлгуулах, хүүхдэд хүндэтгэлтэй хандах, хүсэл мөрөөдөл, юмсын талаар байна ярилцах, сэтгэл зүйн хувьд дэмжих, үйлдлийг нь дэмжих, шүүмжлэхээс зайлсхийж учир шалтгааныг нь тайлбарлах нь чухал юм.

Хүүхдийг ямар нэг үйл ажиллагаанд өөрийн шийдвэрийг нь харгалзахгүйгээр хүчээр оруулах, эсвэл хэтэрхий их анхаарал халамж тавихаас зайлсхийж бие даах чадварыг нь хөхүүлэн дэмжих нь чухал юм.

➤ **Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлогийг дэмжих**

**Танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг дэмжих**

Хүүхдийн танин мэдэхүйн чадварыг дэмжихдээ юуны өмнө анхаарлаа төвлөрүүлэх чадварыг дэмжих нь чухал.

Мэдээллийг тогтоолгохдоо нэг удаадаа дүрс тэмдэгт бол 5-7 байх, үгэн мэдээлэл бол 5-аас хэтрэхгүй байх нь зүйтэй. Хэт олон тохиолдолд анхаарахгүй байх талтай.

Юмсын илэрхий харагдаж байгаа гадаад шинжээр нь харьцуулдаг тул тухайн чадвар дээр нь тулгуурлан юмсын дотоод зүй тогтол холбоо хамаарлыг олох үйлдлийг хөгжүүлэх нь зүйтэй. Маргаан хэлэлцүүлгийн аргаар гэх мэт оролцоонд тулгуурласан аргаар сургалтыг явуулах нь үр дүнтэй.

#### **Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг дэмжих**

Сэтгэлийн хөдөлгөөний хувьд түгшүүрт орох, стресст автагдах нь хялбар тул хүндэтгэлтэй зөөлөн харилцах, алив шийдвэрт саналыг нь асуух, ойр дотно нээлттэй харилцах, олон нитийн үйл ажиллагааны оролцоог нь илүү дэмжих нь үр дүнтэй.

Маргаан хэлэлцүүлгийн аргаар гэх мэт оролцоонд тулгуурласан аргаар сургалтыг явуулах нь үр дүнтэй.

#### **➤ Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөн зан төлөвийн онцлогийг дэмжих**

##### **➤ Танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг дэмжих**

- Анхаарлын төвлөрлийг нь ойр ойрхон татах, харилцахад аль болох нийт дунд нь биш, өөрт нь хандаж харилцаж анхаарлыг нь татах, ойлгосон эсэхийг нь асуух
- Мэдээллийг тогтоолгохдоо дүрс зураг хэлбэртэй бол 6-аас хэтрэхгүй байх, үгэн мэдээлэл бол 4-5 нэгжээс хэтрэхгүй байх нь зүйтэй юм.
- Энгийн гадаад харагдаж байгаа шинжийг нь ажиглуулан, ялгаатай ба нийтлэг төстэй талыг нь олуулах, нэгтгэн дүгнэх үйлдлийг тогтмол хийлгэх нь чухал байна.

##### **➤ Сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлогийг дэмжих**

Сэтгэлийн хөдөлгөөний хувьд хүүхдийн амжилтыг нь магтах урамшуулах, хайр халамжтай байдлаа байнга харуулах, хүүхдийн хүсэл эрмэлзэл мөрөөдлийнх нь талаар ярилцдаг байх, зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах зохицуулах чадварыг нь дэмжих нь зүйтэй.

Хүүхдийн ачааллыг зохицуулахгүй бол хүүхэд маш амархан ядрах, уурлан бухимдах талтай тул үүнд мэдрэмжтэй хандах, ачааллыг нь зохистой түвшинд барих нь чухал юм. Ингэхгүй аваас хүүхэд орчны нөлөөлөлд маш идэвхгүй хандах, анхаарал төвлөрөхгүй, сонирхолгүй байх магадлалтай.

#### **НОМ ЗҮЙ**

Бэгз Н., Санжаабадам С., Лхагвасүрэн Ц., Энхбаяр Б., Баярмаа Б., Баярсайхан Б. (2018). Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур, үзүүлэлт-зөвлөмж. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Бэгз Н., Санжаабадам С., Лхагвасүрэн Ц., Энхбаяр Б., Баярмаа Б., Баярсайхан Б. (2021). Хүүхдийн цогц хөгжлийн оношилгоо, шалгуур үзүүлэлт (6-10 нас). Улаанбаатар: Соёмбо принтинг.

Бэгз Н., Санжаабадам С., Лхагвасүрэн Ц., Энхбаяр Б., Баярмаа Б., Баярсайхан Б., Наранцэцэг Д., Бүрэнжаргал Г. (2021). Нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Лови О. В., Б. В. (1996). Руководство по использованию зрительно-моторного Гештальт-теста Бендер. М.

### Хавсралт 1.

Correlations							
		Харааны хүртэхүйн хөгжлийн түвшин	харааной түвшин	сонорой түвшин	бодит дүрслэлийн сэтгэхүй түвшин	орон зайн дүрслэлийн сэтгэхүй түвшин	хийсвэрсэт гэхүйтүвшин
Харааны хүртэхүйн хөгжлийн түвшин	Pearson Correlation	1	.204	.108	.429**	.472**	.105
	Sig. (2-tailed)		.082	.381	.000	.000	.368
	N	77	74	68	71	71	75
Харааны ой түвшин	Pearson Correlation	.204	1	.240*	.364**	.358**	.205
	Sig. (2-tailed)	.082		.049	.002	.002	.084
	N	74	75	68	72	72	72
Сонорын ойт үвшин	Pearson Correlation	.108	.240*	1	.252*	-.042	.177
	Sig. (2-tailed)	.381	.049		.037	.732	.145
	N	68	68	69	69	69	69
бодит дүрслэлийн сэтгэхүй түвшин	Pearson Correlation	.429**	.364**	.252*	1	.598**	.019
	Sig. (2-tailed)	.000	.002	.037		.000	.874
	N	71	72	69	74	74	72
орон зайн дүрслэлийн сэтгэхүй түвшин	Pearson Correlation	.472**	.358**	-.042	.598**	1	-.060
	Sig. (2-tailed)	.000	.002	.732	.000		.614
	N	71	72	69	74	74	72
Хийсвэр сэтгэхүй түвшин	Pearson Correlation	.105	.205	.177	.019	-.060	1
	Sig. (2-tailed)	.368	.084	.145	.874	.614	
	N	75	72	69	72	72	77

\*\* . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

\* . Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

Correlations		сэтгэлийн хөдөлгөөний онцлог	эрч хүчтэй байдлын түвшин
сэтгэлийн хөдөлгөөний онцлог	Pearson Correlation	1	.308**
	Sig. (2-tailed)		.006
	N	77	77
эрч хүчтэй байдлын түвшин	Pearson Correlation	.308**	1
	Sig. (2-tailed)	.006	
	N	77	79

\*\* . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

## Хавсралт 2.

Descriptives									
		N	Mean	Std. Deviation	Std. Error	95% Confidence Interval for Mean		Minimum	Maximum
						Lower Bound	Upper Bound		
Харааны хүртэхүйн хөгжлийн түвшин	сонсгол	18	3.44	.616	.145	3.14	3.75	2	4
	зан төлөвийн	25	2.68	1.215	.243	2.18	3.18	1	5
	оюуны бэрхшээл	35	2.54	1.067	.180	2.18	2.91	1	5
	тулгуур эрхтний бэрхшээл	12	4.00	1.044	.302	3.34	4.66	2	5
	харааны бэрхшээл	3	4.33	.577	.333	2.90	5.77	4	5
	Total	93	3.00	1.161	.120	2.76	3.24	1	5
түвшин	сонсгол	18	3.94	.873	.206	3.51	4.38	3	5
	зан төлөвийн	24	2.96	1.197	.244	2.45	3.46	1	5
	оюуны бэрхшээл	34	3.00	.985	.169	2.66	3.34	1	5
	тулгуур эрхтний бэрхшээл	12	3.00	1.128	.326	2.28	3.72	2	5
	харааны бэрхшээл	3	3.00	.000	.000	3.00	3.00	3	3
	Total	91	3.18	1.081	.113	2.95	3.40	1	5
харааныойтүвшин	сонсгол	18	3.61	1.037	.244	3.10	4.13	1	5
	зан төлөвийн	24	3.00	1.142	.233	2.52	3.48	1	5
	оюуны бэрхшээл	34	2.65	1.098	.188	2.26	3.03	1	5
	тулгуур эрхтний бэрхшээл	12	2.83	1.267	.366	2.03	3.64	1	5
	харааны бэрхшээл	3	4.00	1.000	.577	1.52	6.48	3	5
	Total	91	3.00	1.164	.122	2.76	3.24	1	5
сонорынойтүвшин	сонсгол	17	2.00	.866	.210	1.55	2.45	1	4
	зан төлөвийн	24	1.75	.676	.138	1.46	2.04	1	3
	оюуны бэрхшээл	28	2.07	.900	.170	1.72	2.42	1	4
	тулгуур эрхтний бэрхшээл	12	2.00	.426	.123	1.73	2.27	1	3
	харааны бэрхшээл	3	1.67	.577	.333	.23	3.10	1	2
	Total	84	1.94	.766	.084	1.77	2.11	1	4
бодит дүрслэлийн сэтгэхүй түвшин	сонсгол	18	3.89	.471	.111	3.65	4.12	3	5
	зан төлөвийн	25	2.80	1.225	.245	2.29	3.31	0	4
	оюуны бэрхшээл	32	3.13	1.040	.184	2.75	3.50	1	5

	тулгуур эрхтний бэрхшээл	12	3.25	.622	.179	2.86	3.64	2	4
	харааны бэрхшээл	3	3.67	.577	.333	2.23	5.10	3	4
	Total	90	3.22	1.014	.107	3.01	3.43	0	5
орон зайн дүрслэлийн сэтгэхүй түвшин	сонсгол	18	3.89	.583	.137	3.60	4.18	3	5
	зан төлөвийн	25	3.04	.889	.178	2.67	3.41	1	4
	оюуны бэрхшээл	32	2.59	.837	.148	2.29	2.90	1	4
	тулгуур эрхтний бэрхшээл	12	3.33	.778	.225	2.84	3.83	2	5
	харааны бэрхшээл	3	4.00	1.000	.577	1.52	6.48	3	5
	Total	90	3.12	.934	.098	2.93	3.32	1	5
сэтгэлийн хөдөлгөөний онцлог	сонсгол	17	1.88	1.054	.256	1.34	2.42	1	4
	зан төлөвийн	25	2.44	1.044	.209	2.01	2.87	1	4
	оюуны бэрхшээл	36	2.50	1.207	.201	2.09	2.91	1	5
	тулгуур эрхтний бэрхшээл	12	2.33	1.073	.310	1.65	3.02	1	4
	харааны бэрхшээл	3	2.33	.577	.333	.90	3.77	2	3
	Total	93	2.34	1.108	.115	2.12	2.57	1	5
эрч хүчтэй байдлын түвшин	сонсгол	18	3.72	.575	.135	3.44	4.01	2	4
	зан төлөвийн	25	3.48	.653	.131	3.21	3.75	2	4
	оюуны бэрхшээл	37	3.65	.824	.135	3.37	3.92	1	5
	тулгуур эрхтний бэрхшээл	12	3.50	.674	.195	3.07	3.93	2	4
	харааны бэрхшээл	3	4.00	.000	.000	4.00	4.00	4	4
	Total	95	3.61	.704	.072	3.47	3.75	1	5